



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020 • XI, XII • № 51, 52

Б.ЛХАГВАСҮРЭН:
БОДЛОГЫН
ШИЙДЛҮҮДИЙГ
ЦАГ АЛДАЛГҮЙ,
ЦОГЦООР НЬ АВЧ
ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР
ХҮНДХЭН
СОРИЛТТОЙ
ЖИЛИЙГ
АМЖИЛТТАЙ
ДАВАН ТУУЛЛАА



МОНГОЛБАНКНЫЭРД ЭНЭСИЙН САНГААСАЛТАН ШАРМАЛ МӨНГӨН ГҮЦ XIX-XX ЗУУН
МӨНГӨ, ХӨӨМӨЛ ЖИН: 575 ГР ӨНДӨР: 17 CM

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



Ковид-19 цар тахалтай 2020 онд авч хэрэгжүүлсэн



Холбоотойгоор Монголбанкнаас жүүлсэн зарим арга хэмжээ





05

ОНЦЛОХ МЭДЭЭ

МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ ОРНУУДЫН ЖАГСААЛТ ("СААРАЛ ЖАГСААЛТ")-ААС ГАРАВ



20

БАЙР СУУРЬ

БОДЛОГЫН ХҮҮГ БУУРУУЛЖ, РЕПО САНХҮҮЖИЛТИЙГ НЭВТРҮҮЛСЭН НЬ ЭДИЙН ЗАСАГТ ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?



11

ЯРИЛЦЛАГА

Б.ЛХАГВАСҮРЭН: БОДЛОГЫН ШИЙДЛҮҮДИЙГ ЦАГ АЛДАЛГҮЙ, ЦОГЦООР НЬ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮНДХЭН СОРИЛТТОЙ ЖИЛИЙГ АМЖИЛТТАЙ ДАВАН ГАРЛАА



25

АСУУЛТ ХАРИУЛТ

МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС



31

МОНГОЛБАНКНЫ МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛБАНК 2020 ОНД 23.6 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА



32

МОНГОЛБАНК ЮУ ХИЙДЭГ ВЭ?

БАНКУУДАД 2020 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД 230 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН РЕПО АРИЛЖААГААР САНХҮҮЖИЛТ ОЛГОВ



35

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

КОВИД-19 БА ЗЭЭЛИЙН ТАСАЛДАЛ



38

СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ ОРНУУДЫН ЖАГСААЛТ ("СААРАЛ ЖАГСААЛТ")-ААС ГАРАВ



Монголбанк 2020 онд багтан Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын "Саарал жагсаалт"-аас гарах зорилтыг тавьж, холбогдох байгууллагуудтай хамтран эрчимтэй ажиллаа. Олон улсад дэгдсэн Ковид-19 цар тахлаас шалтгаалан ФАТФ-ын хяналтын үйл ажиллагаа зогсох шийдвэрийг ФАТФ-ын Ерөнхийлөгч 3 дугаар сард гаргасан хэдий ч, Монголбанк болон Засгийн газраас удаа дараагийн хүсэлт тавьснаар хурлуудыг цахим хэлбэрээр зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангаа амжилттай хамгааллаа. ФАТФ-аас 2020 оны 6 дугаар сард Монгол Улсыг хүлээсэн үүрэг даалгавраа биелүүлсэн тул газар дээрх хяналт шалгалт хийхээр шийдвэрлэснийг зарласан. Үүний дагуу 10 дугаар сард газар дээрх хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулснаар Монгол Улс 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ФАТФ-ын нэгдсэн хуралдаанаар "Саарал жагсаалт"-аас албан ёсоор гарлаа. Уг жагсаалтаас гарахад төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэв. Ийнхүү богино хугацаанд тус жагсаалтаас гарсан нь Монголбанк, түүний дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудын хүчин зүтгэл, хамтын ажиллагааны үр дүн байлаа.


2020 ОНЫ ЭЦЭСТ ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ (ГВАН) 4.5 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН БОСГЫГ ДАВЛАА



Ковид-19 цар тахлын дэгдэлтээс үүдэж 2020 оны эхний хагаст экспорт хурдацтай буурч, Засгийн газрын баталгаатай аж ахуйн нэгжийн бондын төлбөр гадагшаа хийгдэж, урсгал дансны алдагдал өссөн хэдий ч, 2 дугаар хагасаас гадаад орчинд эерэг өөрчлөлт гарлаа. Богино хугацаат гадаад өр төлбөрийг хойшлуулж, доноруудын том дүнтэй санхүүжилт орж ирэн, Монголбанкинд тушаах алтны хэмжээ нэмэгдэж, нүүрсний экспортын хэмжээ өсөв.

Монголбанкнаас валютын нөөцийн тогтвортой, хүрэлцээтэй байдлыг хангах, үнэт металлын худалдан авалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авсны үр дүнд ГВАН 4.5 тэрбум ам.долларын босгыг давж, импортын 11 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрч нэмэгдлээ.

МӨЧЛӨГ СӨРСӨН МӨНГӨНИЙ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ, БОДЛОГЫН ХҮҮГ ТҮҮХЭН ДООД ТҮВШИН БОЛОХ 6 ХУВЬД ХҮРГЭВ



Мөнгөний бодлогын хороо 2020 онд бодлогын хүүг 5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэлээ. Ингэснээр бодлогын хүү түүхэн доод түвшинд ирээд байна. Тус шийдвэр нь Ковид-19 цар тахлын үед нийгэм, эдийн засагт тулгарч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх, дунд хугацаанд инфляцын зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чиглэж байна.

Түүнчлэн мөнгөний бодлогын хүрээнд төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг 4.5 нэгж хувиар бууруулж 6.0 хувьд хүргэх, хүүний коридорыг бодлогын хүүнээс +/- 1 нэгж хувиар тогтоох, жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх, санхүүжилтийн хэмжээг тогтоох зэрэг багц шийдвэрийг гаргав. ЗБН-ийн хувийг ийнхүү бууруулснаар банкуудад 700 гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөгдөв. Энэхүү шийдвэр нь банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах, банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, банкуудын эзэлд гаргах боломжтой эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах, улмаар эдийн засаг дахь санхүүгийн зуучлалыг дэмжих зорилготой байв.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлд дунд хугацаанд инфляцыг 6 хувийн голчтой, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилт тусгасан нь Мөнгөний бодлогын хувьд нэг том алхам болов.

○ ХЯТАДЫН АРДЫН БАНКТАЙ ХИЙСЭН СВОП ХЭЛЦЛИЙН ХУГАЦААГ ГУРВАН ЖИЛЭЭР СУНГАЛАА



Монголбанк, Хятадын Ардын банк хооронд байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох 15 тэрбум юанийн своп хэлцлийн ерөнхий гэрээг 2023 он хүртэл амжилттай сунгалаа. Свop хэлцлийн ерөнхий гэрээг сунгах ажлын хүрээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллаа. Тус гэрээг амжилттай сунгаснаар богино хугацааны гадаад өрийн дарамтыг эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр шийдвэрлэж чадав.

○ МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ХАДГАЛАХ ЧИГЛЭЛД ЗАСГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАВ



Монгол Улсын Засгийн газартай хамтран Монголбанк олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагтай 3-р сарын 25, 5-р сарын 22-нд, Мүүдис агентлагтай 4-р дүгээр сарын 13-нд, Эстэт энд Пи агентлагтай 6-р сарын 3-нд тус тус цахим уулзалт зохион байгуулав. Фитч агентлагаас 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр гаргасан хэвлэлийн мэдээнд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В”, ирээдүйн төлөвийг “Тогтвортой” хэвээр үнэллээ. Зээлжих зэрэглэл харьцангуй тогтвортой байгаа нь Монгол Улс гадаад, дотоод хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалж, Ковид-19 цар тахлын үед гадаад өрийн үйлчилгээг дахин санхүүжүүлэхэд дэмжлэг боллоо.

○ МОНГОЛБАНК 2020 ОНД ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭ БУЮУ 23.6 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА



Гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийг нэмэгдүүлэхэд Монголбанк “Алт-2” хөтөлбөрт дэмжлэг үзүүлж, 2016 онд 18.6 тонн, 2017 онд 20 тонн, 2018 онд 21.9 тонн, 2019 онд 15.2 тонн үнэт металл худалдан авсан бол 2020 он түүхэн дээд хэмжээ буюу 23.6 тонн үнэт металл худалдан авч, ГВАН-ийг 900 орчим сая ам.доллараар нэмэгдүүллээ.

Түүнчлэн энэ оноос Эрдэнэсийн сангийн тухай хуульд заасны дагуу Монголбанкны худалдаж авсан үнэт металлыг гадаадад цэвэршүүлэн мөнгөжүүлж, олон улсын чанарын стандарт хангасан мөнгөн гүлдмай, үрлэн мөнгийг эргүүлэн импортлон оруулж ирж, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнийг анх удаа дотоод зах зээлд худалдан борлуулж эхэллээ. Энэ нь дотоодын уран дархчуудыг чанартай түүхий эдээр хангаад зогсохгүй, уран дарханы өв соёлыг цаашид хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж, дотоодын зах зээл дэх үнэт металлын арилжааг албажуулахад хувь нэмэр оруулах юм. Мөн үнэт металлын арилжаа эрхлэгчдийг Тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлдэг болголоо.

○ БАНКНЫ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭВ



Монголбанк дунд хугацаанд хэрэгжүүлэх “Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж эхлэв. Тус хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр банкны салбарын өөрийн хөрөнгө нэмэгдэн эрүүлжиж, эрсдэл даах чадвар сайжирч, өмчлөл нь олон улсын жишгийн дагуу олон нийтийн өмчийн хэлбэрт шилжиж, банкуудад тавих хөндлөнгийн хяналт нэвтэрнэ. Үйл ажиллагаа нь ил тод тунгалаг болж, шийдвэр гаргах, гүйцэтгэх, хяналт тавих эрх мэдэл хуваагдаж, харилцан бие биедээ хяналттай, тэнцвэртэй эрх мэдэлтэй байх зарчим бий болж, хяналтын тогтолцоо хангагдана. Түүнчлэн олон улсын стандарт, сайн туршлагад нийцсэн зохицуулалтын эрх зүйн орчин бүрдэж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлнэ. Эдгээрийн үр дүнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарын банкинд итгэх итгэл нэмэгдэж, санхүүгийн зуучлал гүнзгийрч, банкны салбарын эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтөд хувь нэмрээ оруулах болно.

ЗЭЭЛИЙН ХҮҮ БУУРАХ ХАНДЛАГА ҮРГЭЛЖИЛЖ, 1.2 НЭГЖ ХУВИАР БУУРЛАА



“Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг 2020 оны 8 дугаар сард Улсын Их Хурал (УИХ)-аар хэлэлцүүлэн батлууллаа. Энэхүү стратегийг 1) зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх, 2) зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, 3) банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах, 4) хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлээр боловсруулав. Энэ хүрээнд Монголбанк, Засгийн газар болон бусад холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтуудыг тодорхой тусгав. Энэхүү стратегид зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувьд хүргэхээр зорилт тавьсан. 2020 онд зээлийн дундаж хүү 1.2 нэгж хувиар буурсан нь дунд хугацааны зорилттой нийцтэй байна. Банкуудын шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2020 оны 11-р сард 15.8%-д хүрсэн нь сүүлийн 9 жилийн хамгийн бага үзүүлэлт юм.

ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХҮҮТЭЙ ЗЭЭЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ОЛГОЖ, ХҮҮГ БУУРУУЛАН, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ ТҮР ХУГАЦААГААР ХОЙШЛУУЛАВ



Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг 2020 онд дахин хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, Монголбанк, банкуудын эх үүсвэрээр энэ оны эхний 9 сарын хугацаанд 8% хүүтэй ипотекийн зээлд 290 тэрбум төгрөгийг 4.0 мянган зээлдэгчид олгосон. Түүнчлэн хөтөлбөрийг зорилтот бүлэгт чиглүүлэх, иргэдийн зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зээлийн хүүг жилийн 6% болгон бууруулж, нийт 120 тэрбум төгрөгийн зээлийг 1.8 мянган зээлдэгчид олголоо. Ингэснээр хөтөлбөрийн хүрээнд энэ онд нийт 410 орчим тэрбум төгрөгийн зээлийг 5.8 мянган өрхөд олгоод байна. Түүнчлэн цар тахлын үед иргэдийн санхүүгийн дарамтыг зөөлрүүлэх зорилгоор өрхийн зардалд томоохон хувь эзэлдэг хөнгөлөлттэй нөхцөлтэй ипотекийн зээлийн төлбөрийг нийт 14 сарын хугацаанд хүү хуримтлуулахгүйгээр үндсэн төлбөрийн хамт хойшлуулах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүллээ. Энэ хүрээнд 2020 оны 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд хүсэлт гаргасан 38,270 зээлдэгчийн нийт 2 их наяд гаруй төгрөгийн зээлийн хугацааг хойшлуулж, иргэдийн амьжиргаанд тодорхой дэмжлэгийг үзүүлсэн. Харин 2 дахь удаагийн арга хэмжээний хүрээнд банкууд орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг 11 дүгээр сараас хойш цахим хэлбэрээр авч байгаа бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 3.2 их наяд төгрөгийн 58,328 хүсэлт ирснээс 57,456 хүсэлтийг буюу 99 хувийг нь шийдвэрлэж эргэн төлөлтийг хойшлуулаад байна. Тус арга хэмжээний хүрээнд зээл авсан өрх бүрт дунджаар нийт 7.7 сая төгрөгийн зээлийн төлбөрийн зардал хэмнэгдэж, энэ хэрээр иргэдийн амьжиргаа, худалдан авалтад эерэгээр нөлөөлөв.

Мөн эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдад зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг холбогдох хуулийн хүрээнд талуудтай хамтран зохион байгуулж, Ковид-19 өвчний голомтод ажиллаж буй нийт 1050 төрийн албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэрээр орон сууцтай болох боломжийг бүрдүүллээ.

ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРГЭН ТӨЛӨЛТ НЬ ХҮНДРЭЛД ОРСОН ЗЭЭЛДЭГЧДИЙН ЗЭЭЛ ТӨЛӨЛТИЙН ХУГАЦААГ СУНГАХ ШИЙДВЭР ГАРГАВ



Ковид-19 цар тахлаас үүдэн эдийн засагт хүндрэл үүсч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсч, зээлийн эрсдэлийн зардал нэмэгдэх, иргэд, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дарамт бий болох бодит эрсдэл үүссэн. Иймд эдгээр эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанкнаас баталж, банкуудад мөрдүүлдэг “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Өр, орлогын харьцааг тооцох аргачлал”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д тус тус холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, зээлийн хугацаа болон бүтцэд өөрчлөлт оруулах,

хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэв. Тус зохицуулалтын арга хэмжээний хүрээнд банкуудаас системийн хэмжээнд 2020 оны 12 дугаар сарын 18-ны байдлаар давхардсан тоогоор 142 гаруй мянган зээлдэгчийн 4.3 их наяд төгрөгийн зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, банкууд нийт 127 гаруй мянган зээлдэгчийн 1.6 их наяд төгрөгийн хэрэглээний зээл болон 2.7 их наяд төгрөгийн 15 гаруйн мянган бизнесийн зээл (үүнд: аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон зээл орно)-ийн бүтцэд өөрчлөлт оруулж, төлбөрийн нөхцөл, хуваарьт өөрчлөлт оруулж, хөнгөлөлт үзүүлсэн байна.

О ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТЫГ ДЭМЖИХЭД ЗОРИУЛСАН УРТ ХУГАЦААТ САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЖ, АШИГЛАЖ ЭХЛЭВ



О ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙГ ТӨРӨӨС НЭГ УДАА ТӨЛӨХ БОДЛОГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАВ



Улсын Их Хурал (УИХ)-аас “Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”-ийг баталсан. Энэ дагуу Монголбанкнаас арилжааны банкууд болон Эрдэнэс Монгол ХХК-тай хамтран хуулийн хэрэгжилтийг хангаснаар тэтгэврийн зээлтэй байсан 228,574 иргэний 694.9 тэрбум төгрөгийн зээлийг нэг удаа төлж, шийдвэрлэлээ.

О НОМАД БОНДЫГ ГАРГАХ, МАЗААЛАЙ, ЧИНГИС БОНДЫН ТОДОРХОЙ ХЭСГИЙГ ДАХИН САНХҮҮЖҮҮЛЭХ АЖИЛД МОНГОЛБАНК ЗАСГИЙН ГАЗАРТАЙ ХАМТАРЧ АЖИЛЛАВ.



Монголбанкнаас Монгол Улсын засгийн газрын гадаад зах зээлд гаргасан бондуудыг дахин санхүүжүүлж, гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулахад Засгийн газартай хамтран ажиллав. Цар тахлын үед дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) оны эхний хагаст 9.7 хувиар агшсан, Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын хяналтын жагсаалтад орсон, экспорт буурсан зэрэг гадаад орчны таагүй нөхцөл байдлын үед Номад бондыг харьцангуй бага 5.125% хүүтэйгээр гаргаж, дахин санхүүжилтийг амжилттай хийв. Тухайлбал, 600 сая ам.долларын Номад бондыг олон улсын зах дээр гаргаснаар 2021 онд эргэн төлөгдөх Мазаалай бондын 380 сая ам.доллар, 2022 оны Чингис бондын 220 сая ам.долларын дахин санхүүжилтийг хийлээ.

МӨНГӨН ДЭВСГЭРТҮЙН ХАМГААЛАЛТЫН ЭЛЕМЕНТҮҮДИЙГ САЙЖРУУЛЖ, НӨӨЦИЙГ ДАХИН БҮРДҮҮЛЭВ



Монгол улс ардчилсан зах зээлийн нийгэмд шилжсэнээр 1993 оноос үндэсний мөнгөн дэвсгэртээ шинэчилсэн. Түүнээс хойших хугацаанд анх удаа олон улсын дэвшилтэт шинэ технологиор мөнгөн дэвсгэртний хамгаалалтын элементүүдийг сайжруулж, дүрслэлүүдийн чанар, өнгө үзэмжийг нэмэгдүүлснээр хуурамчаар үйлдэхээс хамгаалагдсан дэлхийн жишигт хүрсэн мөнгөн дэвсгэрттэй боллоо. Түүнчлэн харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан элементийг нэмсний зэрэгцээ шинэчлэгдсэн мөнгөн дэвсгэртүүдийг хуурамчаас ялган танихад зориулсан танин мэдэхүйн мэдээлэл бүхий гар утасны аппликэйшн гаргаж, нэвтрүүлэхээр ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ИЙН НАЙДВАРТАЙ, ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАЖ АЖИЛЛАЖ, ҮНДЭСНИЙ ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ ТӨВ (ҮЦГТ)-ИЙГ ШИНЭЧЛЭВ



ҮЦГТ-ийн дата төвийг шинэчилж, үндэсний төлбөрийн системийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, техник технологийн шинэ боломжийг бүрдүүлэх зорилгоор ҮЦГТ-ийн барилгыг шинээр барьж, ашиглалтад оруулах бүтээн байгуулалтын ажлыг амжилттай гүйцэтгэж дууслаа. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд баригдсан энэхүү дата төвд цахилгааны олон талт эх үүсвэр, орчин үеийн шийдэл бүхий хөргөлтийн систем, гал, усны найдвартай хамгаалалт бүхий 36-н зогсоогуурыг бий болгосон. Тус төв нь мэдээллийн технологийн дата төвийн стандартыг олон улсын хэмжээнд тогтоодог нэр хүнд бүхий Uptime Institute-ийн байгууллагын TIER II стандартад нийцсэн орчин хамгийн шинэлэг дэд бүтэцтэй төв болж чадлаа. ҮЦГТ-ийн шинэ барилга нь Монголбанкны түүхэнд бичигдэх бүтээн байгуулалт болж байгаа бол дата төвийн шинэчлэл нь Монгол Улсын төлбөрийн системийн хөгжилд нэгэн шинэ дэвшлийг авчирсан үйл явдал боллоо.

Монголбанкнаас Ковид-19 цар тахлын үед бэлэн бус төлбөр тооцоо буюу карт, интернет, мобайл гүйлгээг өргөнөөр ашиглахыг олон нийтэд уриалж, энэ үед төлбөр тооцоог бодит цагийн горимоор, тасралтгүй дамжуулж байна. Монголбанкнаас банк хоорондын бага дүнтэй “Автомат клиринг хаус” (ACH+), их дүнтэй “Банксүлжээ”, төлбөрийн картан системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангахын зэрэгцээ банкуудын системээр дамжуулдаг гадаад төлбөр тооцоонд аливаа эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

БАНК, САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, ДЭВШИЛТЭД ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ДЭХ ФИНТЕК КОМПАНИУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭВ



Үндэсний төлбөрийн системийн тухай хууль нь зөвхөн банкууд оролцдог байсан төлбөрийн системийн хамрах хүрээг тэлж, хуулийн этгээдэд төлбөрийн үйлчилгээ үзүүлэх боломжийг олгож, Монгол Улсын банк, санхүүгийн салбарт эрх зүйн шинэ орчинг бүрдүүлсэн. Тус хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2020 онд шинэ дэвшилтэд технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэхийг зорьж буй финтекийн 8 байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу төлбөрийн үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олголоо. Зөвшөөрөл бүхий байгууллагаас Ард кредит ББСБ ХК болон Хай пэймэнт солюшнс ХХК-ийг Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний “Автомат клиринг хаус” системд холбож, RTP буюу бодит цагийн горимд төлбөр тооцоо дамжуулах системийг амжилттай нэвтрүүллээ. Финтекийн компанийг үндэсний төлбөрийн системийн үндсэн орчинд амжилттай холбосноор төлбөр тооцоог бодит цагийн горимоор гүйцэтгэх, төлбөрийн үйлчилгээг илүү хялбар, шуурхай, найдвартайгаар иргэд, харилцагчид хүргэх нэгэн шинэ гарцыг нээж байгаа бөгөөд энэ нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилт юм. Монголбанкнаас нэгтгэн гаргадаг статистик мэдээллийн хүртээмжийг сайжрууллаа.

ИРГЭДЭД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ, САНХҮҮГИЙН ЛУЙВАРТАЙ ТЭМЦЭХ ЦУВРАЛ АЯНУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭВ



Олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих бодлогын хүрээнд санхүүгийн залилан луйвраас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх мэдлэг, мэдээллийг олгох зорилгоор “Ятгах тусам нягтал”, “Нягтлах тусам аюулгүй” цуврал аяныг Цагдаагийн Ерөнхий газар, Монголын банкны холбоо болон арилжааны банкуудтай хамтран улсын хэмжээнд жилийн турш зохион байгууллаа. Аяны үр дүнд гэмт хэргийн улмаас иргэн, байгууллагад учирсан хохирлын хэмжээ буурч, хэрэг бүртгэл 2020 оны эхний 11 сарын үзүүлэлтээр 9 хувь буурсан бол хэрэг шийдвэрлэлт 26 хувь өсчээ.

Банкны салбарын хүрээнд жил бүрийн 10 дугаар сард Дэлхийн хуримтлалын өдрийг тэмдэглэж ирсэн бол 2020 онд оролцогчдын цар хүрээг нэмэгдүүлж, “Дэлхийн хуримтлалын өдөр-2020” аяныг бусад байгууллагуудтай хамтран Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Баруун-Урт хотуудад тэмдэглэлээ. Мөн мөнгөн тэмдэгтийн зохистой хэрэглээг дэлгэрүүлэх, мөнгөн тэмдэгтийн насжилтыг уртасгах, улмаар үүнтэй холбоотой гарах зардлыг бууруулах зорилгоор “Халаасанд бус хэтэвчинд-Овоонд бус хэрэглээнд” аяныг улс орон даяар хэрэгжүүлэв.

МОНГОЛБАНКНААС НЭГТГЭН ГАРГАДАГ СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛЛАА



Монголбанкнаас нэгтгэн боловсруулдаг статистик тоон мэдээлэл, тайлангуудыг шинэчилж, статистик мэдээллийн stat.mongolbank.mn болон банкуудын зарласан хүүний мэдээллийн bankrate.mongolbank.mn цахим хуудаснуудыг шинээр ашиглалтад оруулснаар санхүүгийн хэрэглэгчдэд мэдээллийн тэгш хүртээмжийг бий болгох, улмаар банкуудын зээлийн бүтээгдэхүүний өрсөлдөөнийг дэмжих боломжийг нэмэгдүүллээ. Мөн статистик болон тайлан мэдээллийг Монголбанкны цахим хуудасны монгол, англи хувилбараар дамжуулан олон нийтэд хүргэхээс гадна иргэдэд илүү хүртээмжтэй, ойлгоход хялбар болгох үүднээс зээлийн хүү, харилцах, хадгаламжийн хүү, инфляц, гадаад өр, Ковид-19 үеийн арга хэмжээ, банкны салбарын үзүүлэлтүүд, төлбөрийн тэнцэл зэрэг статистик, тоон үзүүлэлтүүдээр цуврал инфографик бэлтгэн олон нийтэд тогтмол хүргэж байна.

МОНГОЛ УЛС ОУВС-ТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА АМЖИЛТТАЙ ҮРГЭЛЖЛҮҮЛЖ, “ШУУРХАЙ САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД ЭХ ҮҮСВЭР АВАВ



Монгол Улс ОУВС-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг 3 жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлж, үргэлжлүүлэн “Шуурхай санхүүжилтийн хөтөлбөр” (RFI)-ийн хүрээнд санхүүжилт аваад байна. Тодруулбал, дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай даван туулах, төсөв болон төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Монголбанк хамтран ОУВС-ийн Шуурхай санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдаж, 99 сая ам.долларын санхүүжилтийг авав.

МОНГОЛБАНК FORBES MONGOLIA PROPERTY AWARDS ШАГНАЛ ХҮРТЛЭЭ



Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд Монголбанк нь санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэхээр заасан. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хуульд нийцүүлэн шаардлагатай арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, иргэдийг хөнгөлөлттэй зээлээр орон сууцжуулах хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Төрөөс хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлтэй ипотекийн зээлийг илүү хүртээмжтэй болгоход чиглэсэн Монголбанкны бодлого, үйл ажиллагааг үнэлж, Forbes сэтгүүлээс зохион байгуулдаг “Forbes Mongolia Property Awards” шалгаруулалтаас “Барилгын салбарын амжилт” шагналыг олгов.



Б.Лхагвасүрэн: БОДЛОГЫН ШИЙДЛҮҮДИЙГ ЦАГ АЛДАЛГҮЙ, ЦОГЦООР НЬ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮНДХЭН СОРИЛТТОЙ ЖИЛИЙГ АМЖИЛТТАЙ ДАВАН ГАРЛАА

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнгийн 2020 оны төгсгөлд Блүүмбэрг ТВ-ийн захирал Э.Долгионтой хийсэн ярицлагыг уншигч танаа толилуулж байна.

Нийгэм бүхэлдээ 2020 онд хүнд жилийг үүрлээ. гэхдээ хамгийн дорвитой бөгөөд хүнд ачааг үүрсэн байгууллага нь яах аргагүй танай байгууллага буюу Монголбанк. энэ жилийг та маш товчхон дүгнэж хэлбэл, 2020 он яаж эхлэв, одоо яаж дуусч байна вэ?

- 2020 оны нэгдүгээр сараас Засгийн газар Ковид-19 цар тахлын улмаас хорио цээрийн дэглэм тогтоож, үүнийг дагаад эдийн засгийн идэвхжил сулраад эхэлсэн. Гадаад хамтын ажиллагаа ч мөн ялгаагүй хил гааль дахь хорио цээрийн улмаас түр саатах, зогсох зэргээр асуудлууд үүссэн. Үүгээр манай эдийн засаг хүндхэн сорилттой тулгарсан. Эдийн засаг дахь хамгийн том гол санхүүжилт, түүний өртгийг тодорхойлдог байгууллага нь Монголбанк. Энэ утгаараа Монголбанкны

хувьд шууд сорилт эхэлсэн юм. Бид 2020 оныг эхлүүлж байхдаа энэ онд ямар ч байсан хятадын Ардын банкны своп хэлцлийг сунгана, ОУВС-ийн хөтөлбөрийг амжилттай дуусгахын төлөө ажиллана, эдийн засгийн өмнөх 3 жилийн хугацааны 5-7 хувийн эдийн засгийн өсөлтийг яаж хадгалах вэ зэрэгт бүх анхаарлаа хандуулж, бодлогынхоо шийдвэрийг гаргачихсан байсан. Гэтэл дэлхий дахинд Ковид-19 цар тахал нүүрлэснээр бодлогын шийдлүүдээ эргэн харах шаардлага гарч, үүнтэй уялдсан оновчтой, зөв өөрчлөлтүүд хийхэд анхаарсан. Ковид нь таны дурдсанчлан улс орон бүр, тэр дундаа иргэн, аж ахуйн нэгж болгонд тодорхой хэмжээний нөлөө, дарамт учруулж байгаа учраас, манай улс яаж зөөлөн тусгах вэ гэдэгт бүхий л бодлогын шийдвэрээ чиглүүлсэн. Тиймээс

маш тактикийн шинжтэй ажилласан гэж хэлж болно. Төв банкны тухай хуулиар Мөнгөний бодлогын хороо улиралдаа нэг удаа хуралдаж, бодлогын шийдвэр гаргадаг бол 2020 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 7 удаа хуралдаж, мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх нь зүйтэй гэдэг санал дээр шийдвэрээ гаргаж, бодлогын хүүг 6 хувь буюу түүхэн доод хэмжээнд хүргэсэн. Гэхдээ үүгээр болчихно гэж төсөөлөлгүйгээр эдийн засагт аль болох хурдан үр дүнг үзүүлэхийн тулд дунд хугацаанд үйлчлэлээ үзүүлдэг мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарсан цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн. Цухас дурдвал, мөнгөний бодлогын хүүг бууруулахдаа заавал байлгах нөөцийг бууруулж, үүнтэй зэрэгцүүлэн Монголбанкны зээлийн хүүний



Нөгөө талаар төлбөрийн тэнцэл дээр харах юм бол ихэнх нь үйлчилгээний шинжтэй, томоохон зардлууд хэмнэгдсэн байна. Ялангуяа, аялал жуулчлалын салбарыг авч үзвэл -500 сая ам.долларын алдагдалтай байдаг уг салбарт гадны жуулчдын оруулдаг мөнгөнөөс давсан хэмжээнд манай иргэдийн гадаад аялалд зарцуулдаг зардал, гадаад тээврийн үйлчилгээний хөлс, гадны нарийн мэргэжлийнхэнд өгдөг үнэ хөлс зэрэгт гадагшилдаг мөнгөн урсгал хэмнэгдсэн.



Нөхцөл байдлыг гадаад болон дотоод гэж хоёр хувааж үзвэл гадаад хүчин зүйлийг бид өөрийнхөөрөө байлгах боломжгүй. Гэхдээ гадаад талдаа Монгол Улс 2020 оны хувьд үнэхээр "ургацтай" жил байсан гэж дүгнэж болохоор байгаа шүү дээ. Гэвч хамгийн их санаа зовоож байсан асуудлыг та юу гэж үзэж байна вэ?

- Манай улсын гадаад худалдааны хамгийн том түнш болох БНХАУ –ын Ухань мужаас Ковид-19 илэрснээр анхны голомт бүхий улс болж,

коридорыг нарийсгасан зэрэг их олон арга хэмжээг багцаар нь авч хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрсэн гэж үзэж байна. Үүний илрэлийг ДНБ-ий өсөлтөөр тайлбарлаж болно. 2020 оны нэгдүгээр улиралд ДНБ-ий өсөлт -10.7, хоёрдугаар улирлын эцсээр -9.7 хувьтай гарсан нь өмнөх жилтэй харьцуулахад маш ихээр агшсан үзүүлэлт байсан. Тэгвэл бодлогын шийдлүүд үр дүнгээ өгч эхэлснээр есдүгээр сарын эцэс буюу 3 дугаар улиралд -7.3 хувь болж, оны эцэс рүү Монголбанкны төсөөллөөр -6 орчим хувь болж агшихаар байна. 2020 он эхлэхэд 11 орчим хувиар унаж байсан эдийн засаг оны төгсгөлд -6 орчим хувь болсон нь эдийн засаг харьцангуй сэргэж байгааг харуулж байна. Энэ эрчээ хадгалсан бодлого үргэлжилбэл, 2021 онд Монгол Улсын эдийн засаг 5-6 орчим хувийн өсөлттэй гарч, сэргэх төсөөлөлтэй байна.

энэ нь оны эхний хагасаас манай гадаад орчинд таагүй нөлөөлж эхэлсэн. Гэтэл бид экспортынхоо 90 хувийг БНХАУ-руу гаргаж, импортынхоо 40 орчим хувийг авдаг. Харин оны сүүлийн хагаст хорио цээрийн дэглэм суларч, экспорт сэргэж эхэлсэн нь БНХАУ голомтоо богино хугацаанд барьж чадсантай холбоотой. Энэ нь манай гадаад орчинд эерэг нөлөө үзүүлсэн. Нөгөөтэйгүүр манай улсын экспортын голлох нөлөөг үзүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний түүхийн эдийн үнэ огцом саарсангүй, оны төгсгөл рүү өсч эхэллээ. Үүний нэг үр дүнд Монголбанк түүхэн дээд хэмжээнд буюу 23.6 тонн үнэт металл худалдаж авлаа. Үүний 90 хувь нь алт юм. Ковидын эсрэг арга хэжээний хүрээнд бусад засгийн газар, төв банкуудын хэвлэсэн асар их хэмжээний мөнгөний урсгалаас зугтсан хөрөнгө алт руу төвлөрсөнөөр алтны үнийг сайн өсгөлөө. Хэсэгхэн хугацаанд унц алтны үнэ 2000 ам.долларыг давсан ч одоо 1800 орчим дээр тогтворжсон байгаа нь сүүлийн хэдэн жил дэх дээд өсөлт юм. Яг энэ үед нь Монгол Улс 23.6 тонн үнэт металл худалдан авч экспортолсон нь нүүрсний энэ оны экспортын орлогыг орлох хэмжээнд дүйцэж хүрсэн нь их таатай үр дүн юм. Нөгөө талаар төлбөрийн тэнцэл дээр харах юм бол ихэнх нь үйлчилгээний шинжтэй, томоохон зардлууд хэмнэгдсэн байна. Ялангуяа, аялал жуулчлалын салбарыг авч үзвэл -500 сая ам.долларын алдагдалтай байдаг уг салбарт гадны жуулчдын оруулдаг

мөнгөнөөс давсан хэмжээнд манай иргэдийн гадаад аялалд зарцуулдаг зардал, гадаад тээврийн үйлчилгээний хөлс, гадны нарийн мэргэжлийнхэнд өгдөг үнэ хөлс зэрэгт гадагшилдаг мөнгөн урсгал хэмнэгдсэн.

Тэгэхээр ковидтой холбоотой нөхцөл байдлыг эерэг талаас нь авч үзвэл гадаад талаасаа манайд ингэж сайнаар тусаж байна. Гэтэл олон улсын хувьд авч үзвэл, цар тахал тэдэнд яагаад хүнд тусаж байна вэ гэдгийн цаад шалтгаан нь олон улсын хамтын ажиллагаа өртгийн болон нийлүүлэлтийн асар том сүлжээн дээр тогтож байгаатай холбоотой. Гэтэл Монгол Улс энэ сүлжээнд хамрагдаж чадаагүй нь бидний хөгжлийн хоцрогдолтой холбоотой ч яг одоогийн хүнд үед харин ч ашигтай туслаа. Үүнийг тодорхой тайлбарлахын тулд энгийн л нэг жишээ авъя. I Phone утас хэдийгээр АНУ-ын брэнд бүтээгдэхүүн боловч дэлхийн 50-60 орноос ирсэн төрөл бүрийн эд ангиудын нэгдэл байдаг. Хэрвээ бид тэдгээр эд ангийн аль нэгийг нь хийж чаддаг бол бидэнд асар их боломж нээгдэнэ гэсэн үг. Хэдэн зуун саяараа зарагдаж байгаа бүтээгдэхүүн дотор жижигхэн, нэг долларын ч болов өртөг шингээвэл тэр хэмжээгээрээ ашиг олно гэсэн үг. Тэгэхээр энэ мэт өртгийн сүлжээнүүдэд ковидын царх тахлын хөл хорионоос болж хүндрэлүүд үүсээд байна. Харин бидний хувьд тийм саад гарахгүй шүү дээ. Энэ утгаараа

гадаад талаасаа хүндрэл бага байна гэж харж байна.

Монгол Улсын валютын нөөц яг одоогоор хэчнээн тэрбум долларт хүрээд байна вэ?

- Оны сүүлийн байдлаар 4.5 тэрбум ам.долларт хүрсэн. Энэ бол түүхэн дээд хэмжээнд хүрсэн үзүүлэлт. Үүнээс өмнө Монгол Улсын эдийн засаг өсөлттэй байсан 2019 онд ГВАН 4.3 тэрбум ам.доллар болж, өндөр амжилтыг үзүүлж байсан ч 2020 он гарах үед валютын нөөц энэ хэмжээнээсээ нэлээд буурах боловчуу гэсэн хүлээлттэй байсан. Гэсэн ч хэвийн үеийнхээсээ ч өссөн дүнг үзүүлсэн нь бодлого зөв оновчтой байсныг харуулж байна. Энэ онд гадагшаа урсгал огт байгаагүй гэж хэлэхгүй. Ерөнхийдөө импорт 20 хувиар агшсан ч 4 тэрбум ам.долларын импорт хийсэн хэвээрээ л байгаа. Үүний нөгөө талд экспорт сайжирсан. Мөн алтны экспорт нэмэгдсэн зэрэг нь валютын нөөц нэмэгдэхэд томоохон хувь нэмрийг оруулсан. Дээр нь томоохон дүнтэй гадны төлбөрүүд хийгдсэн. Худалдаа хөгжлийн банкны 500 сая ам.долларын бондын төлбөр, Монгол Улсын өндөр дүнтэй өр төлбөрүүдийн хүүний зардалд бараг 200-300 сая ам.долларыг төлсөн. Үндсэндээ өрийн удирдлагын менежментийг сайн хийсний хүчинд валютын нөөц өссөн гэж хэлж болох юм. Үүнээс гадна гадаад валютын нөөцийнхөө тодорхой хэсгийг бид олон төрлийн валютаар барьдаг.

Тэдгээр валютын тогтвортой байдал ч бас нөөц өсөхөд нөлөөлсөн.

Тэгвэл гадна талдаа итгэл төрүүлсэн үйл явдлууд болж байсан учраас харьцангуй зөөлөн байлаа гэж ойлгож болох нь ээ.

- Тийм. Ялангуяа, судлаачид үүнийг маш нарийн ажигласан байх. Худалдаа хөгжлийн банкны бондын төлбөрийг төлөхөөс өмнө манай улсын олон улсын зах зээлд гаргасан бондуудын өгөөж дэлхийн бусад улсуудынхтай адил 2 оронтой тоо руу буюу 15, 20 хувь руу хүрсэн байсан. Харин төлбөр хийгдсэний дараа эргээд анх нэрлэсэн 4-5 хувийн түвшиндээ очсон. Одоо бол манай бондууд 4-5 хувийн өгөөжтэй буюу маш эрсдэл багатай гэсэн ангилал руугаа орсон байгаа. Учир нь манай улсын төлбөр тооцоо цаг хугацаандаа хийгдэж, нөөц хуримтлагдаж, ханш тогтвортой байгаа зэрэг үзүүлэлт нь гадны хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалж чадаж байгааг харуулж буй хэрэг юм. Түүнчлэн 2020 онд Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсангүй. Гэтэл дэлхийн 60 гаруй орны зэрэглэл буурсан байгаа шүү дээ. Энэ нь юуг хэлж байна вэ гэхээр хэдийгээр ковидын хүнд үе ч гэлээ манай улсын олон улсад итгэл хүлээлгэх зэрэглэл буруугүй гэдэг нь бид тодорхой хэмжээнд зөв ажиллаж чадаж байгаагийн тод илрэл болов уу.

Хятадын Ардын банкны своп хэлцлийг сунгасан гэдгийг та дурдсан. Төлөх хугацаа нь

ирвэл, төлбөрөө бүрэн төлөх үү, эсвэл дахиад сунгах уу. Ямархуу төлөвлөгөөтэй байгаа вэ?

- Нэгэнт БНХАУ нь манай гадаад худалдааны хамгийн том түнш орны хувьд худалдаан дээр хоёр орны мөнгөн тэмдэгийн своп хамгийн сайн нөлөөтэй. Своп нь бүх улс орнуудад хийгддэг. Тухайлбал, ковидын үед Америкийн төв банк свопыг илүү их ашиглаж, түнш орнууд болох Япон, Хятад, Европын холбоотой зэрэгтэй хэлцэл хийгээд байгаа нь хорио цээрийн дэглэмийн үед худалдаагаа хадгалах гэсэн зорилготой юм. Монгол Улсын төв банк, Хятадын Ардын банк хоорондын своп хэлцэл нь төгрөг, юанийн төлбөр тооцоог хоёр орны худалдаанд илүүтэй ашиглах байдлаар 2011 онд анх байгуулсан. Өнөөдрийн байдлаар 12 тэрбум юанийн хэмжээнд хүрчихсэн байна. Монгол Улс энэ мөнгийг авч ашигласан учраас бидний хувьд өр гэж бүртгэгдэх болсон. 12 тэрбум юань гэдэг нь 1.7 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний өр. Монгол Улсын валютын нөөц 4.5 тэрбум ам.долларт хүрсэн учраас энэ өрийг хангалттай төлөх хэмжээний нөөцийг бүрдүүлж чадсан гэсэн үг. Гэхдээ энэ жил уг төлбөрийг хойшлуулсан нь 2021 оны эхээр төлөх ёстой Засгийн газрын “Мазаалай”, 2022 оны эхээр төлөгдөх “Чингис” зэрэг бондуудын төлбөрт тодорхой хэмжээний нөөцийг хадгалах шаардлагатай байгаа юм. Хугацаа ашиглаад өр төлөх эх үүсвэрээ бүрдүүлэх

боломжоо бүрдүүлнэ. Монгол Улсад хамгийн том гэгдэх мега төслүүдийг хэрэгжүүлчих юм бол тэр хэмжээний өрийг 1-2-хон сарын орлогоор нь төлөх боломжтой. Тийм учраас өнөөдрийн хувьд санхүүжилтийн эх үүсвэр нь Монголдоо байх нь зөв гэж үзээд ийм шийдвэрийг гаргасан. Нэг ёсондоо мега төслүүдээ ажиллуулаад эхэлбэл, 2022, 2023 онд төлөх томоохон өрүүдийг төлөхөд хангалттай нөөцтэй байж чадна гэж харсан бодлогын шийдэл юм.

Гадаад нөхцөл байдлаасаа дотоод сэдэв рүүгээ орё. Энэ жилийн хувьд олон нийтийн анхаарлын төвд байсан гол сэдэв нь зээлийн хүү байлаа. Талцал, хуваагдлууд гарсан ч нэг сайн тал нь зээлийн хүүг хэн нэг нь дураараа тогтоодоггүй юм байна гэдгийг нийгэм сайн ойлголоо. Үр дүнд ч зээлийн хүү буурсан. Тэгэхээр цаашид энэ трэндээ хадгалаад, зээлийн хүү буурах уу, ер нь энэ нөлөөллийг хэрхэн харж байна вэ?

- Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжээд 30 жил болсон байна. Энэ хугацааг туулах явцад шийдэгдээгүй олон асуудал таны сая хэлсэнчлэн нийгмийн хэлэлцүүлгийн үеэр анхаарал татаж байна. Гол нь шийдвэрлэх арга замаа олох нь чухал байгаа юм. Энэ нь санхүүжилтийн өртөгийн тухай асуудал. Санхүүгийн зах зээлээ харах бол маш өрөөсгөл. Зөвхөн банкинд суурилсан. Нийт эргэлдэж байгаа мөнгөний 90 хувь нь банкинд төвлөрч

байна. Үлдсэн арван хувийн хувьд ойлгомжтой. Ингээд банк өрсөлдөгчгүй салбар болчихоод байна. Тэгэхээр үүнд анхаарсан бодлогын нэг хэлбэр нь УИХ-аар батлуулсан “Зээлийн хүүг бууруулах стратеги” юм. Үүнийг хийхийн тулд бид томоохон судалгаануудыг хийсэн. Эндээс үзэхэд банкны зээлийн хүү өндөр тогтоход эх үүсвэрийн хүү 60 хувийг эзэлж байгаа нь гол нөлөөг үзүүлдэг юм байна. Үлдсэн 40 хувь нь банкны үйл ажиллагаа, технологийн шинэчлэл болон бусад зардлаас, тэр дундаа эрсдэлийн зардал нэлээд өндөр буюу 17 хувийг нь бүрдүүлж байна. Эндээс Монгол Улсад санхүүгийн сахилга бат муу байгааг харж болно. Банкнаас зээл авчхаад төлөхгүй, хууль шүүхээр 5-7 жил хүртэл маргаан үүсгээд явж байдаг бодит жишээ цөөн биш. Тэгэхээр хууль эрх зүйн орчны хувьд зайлшгүй шинэчлэгдэх шаардлагатай байна. Бид үүн дээр ажиллаж, зээл авсан бол төлдөг байх санхүүгийн сахилга батыг суулгасан олон улсын жишгийн нэвтрүүлэх хэрэгтэй гэх мэтчилэн сайжруулах зүйлс бий. Түүнчлэн эх үүсвэрийн зардал буюу харилцах, хадгаламжийн зардлыг бууруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэн, хууль эрх зүйн шинэчлэлүүдийг хийж байна. Одоогоор харилцах данс, хугацаагүй хадгаламжид хүү төлөхийг зогсоох гэж байна. Мөн эх үүсвэрийн зардлыг бууруулахад төв банкны оролцоотойгоор бодлогын хүүг бууруулж байна. Аль ч улсад төв банк эцсийн зээлдүүлэгчийн үүргийг гүйцэтгэдэг. Хаанаас

ч мөнгө олж чадахгүй болсон үедээ банк төв банканд ханддаг. Энэ утгаараа бид бодлогын хүүг 6 хувь руу аваачиж, төгрөгийн өгөөжийг багасгаж байгаа нь зээлийн хүүг бууруулах бодлогын суурь шийдэл болж чадах ёстой. Үүнээс гадна дээр дурдсанчлан хөрөнгийн биржийг зайлшгүй хөгжүүлж, банктai өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх шаардлагатай. Өнөөдөр ард иргэд зээлийн хүү өндөр байгаад шүүмжлэлтэй хандаж буй нь санхүүгийн зах зээлийн өрөөсгөл бүтэцтэй холбоотой. Гэтэл зах зээл өндөр хөгжсөн орнуудад санхүүжилтийн нэг номрын сонголт нь хөрөнгийн бирж байдаг. Өнөөдөр Блүүмбэргийн гол сэдэв дэлхийн хамгийн том IPO буюу Хятадын "Алибаба"-ийн хийх гэж байгаа IPO-ийн тухай байх жишээтэй. Том бизнес хийх гэж байгаа хүн санхүүжилтээ хөрөнгийн биржээс л авдаг. Тэгэхээр хөрөнгийн бирж хөгжиж байж Монгол Улсад бизнес хэвийн хэмжээнд явж, зээл биш өөр санхүүжилт авах бололцоотой болно.

Гэхдээ дунд болон урт хугацаанд Монгол Улсад зээлийн хүү буурах суурь, эхлэл нь тавигдсан гэж ойлгож болох уу?

- Монголбанкны хийсэн судалгаагаар 2016-2020 онд Монгол Улсад зээлийн дундаж хүү 4 нэгж хувиар буурсан. 2016 оны эцэст зээлийн дундаж хүү 20 хувь байсан бол 2020 оны эхээр 16 хувьд хүрч, жилд 1 нэгж хувиар буурсан нь 1990

онд зах зээлд шилжсэнээс хойших хамгийн огцом буурсан үе болж байна. Цаашид энэ хурдаа хадгалбал, 2023 оны эцэс гэхэд хүү 12 хувьд хүрэх бололцоотой гэж харж байна. Гэхдээ бодлогын арга хэмжээгээр давхар нөлөөлөх нь илүү хурдацтай буурах боломжтой. Тухайлбал, төрөөс санхүүжилттэй ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүүг 8 хувиас 6 хувь болгож бууруулж чадлаа. Тэгэхээр орон зай бидэнд байна. Дээр нь дундаж хүүг буулгаснаар төв банкны зүгээс тодорхой хэмжээний эх үүсвэрийг гаргаад эхэлбэл хүү буурах боломжтой. Эх үүсвэрийн дундаж зардал ер нь буураад эхэлсэн. Монголбанкны бодлогын сүүлийн шийдвэрийн дараа Монгол Улсын хамгийн том банк өөрийн хадгаламжийн жилийн хүүг 9.8 хувь гэж зарлалаа. Зах зээлд шилжсэн сүүлийн 30 жилд хадгаламжийн хүү нэг оронтой тоогоор хэмжигдэж байсан үе байхгүй. Энэ нь юуг харуулж байна вэ гэвэл эх үүсвэрийн хүү, зээлийн хүү, бодлогын хүү ч тэр нэг оронтой тоо руу орох суурь, орон зай бий болсныг илэрхийлж байна.

Зээлийн хүү банкуудад 15-20 хувьтай байна. Гэхдээ жилийн 1000 хувь давсан зээлийн хүү санхүүгийн бусад салбарт байна. Банкны салбарын хувьд Монголбанк зохицуулан, хянаж байна. Гэтэл хараа хяналтгүй байгаа ийм төрлийн жижиг зээлүүдийг хэрхэх вэ?

“Нийт эргэлдэж байгаа мөнгөний 90 хувь нь банкинд төвлөрч байна. Үлдсэн арван хувийн хувьд ойлгомжтой. Ингээд банк өрсөлдөгчгүй салбар болчихоод байна. Тэгэхээр үүнд анхаарсан бодлогын нэг хэлбэр нь УИХ-аар батлуулсан “Зээлийн хүүг бууруулах стратеги” юм.

“Ипотекийн зээлийг өнөөдөр 99 мянга гаруй иргэн авч, зээлийн хэмжээ 4 их наяд гаруй төгрөгт хүрсэн байна. Энэ төрлийн зээлийн хувьд чанаргүйдсэн үзүүлэлт нь ердөө 1 хувь байна. Олон улсын жишгээр ипотекийн зээлийн хувьд чанаргүй зээлийн үзүүлэлт нь 1-2 хувь л байдаг. Бидний хувьд 1 хувь байна гэдэг нь дэлхийн жишигтэй адилхан.”

- Захиргаадалтын арга хэмжээ авбал, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж буурдаг гэсэн судалгаа бий. Тэгэхээр анх зээлийн хүүг бууруулах асуудал яригдаж байхад хүүний дээд хязгаарыг тогтооно гэж ярьдаг байсан. Тэгэхээр таны хэлж байгаачлан зарим тохиолдолд жилийн 1000 хувийн хүүтэй зээл манай зах зээлд байна. Өдрийн зээл, ломбардын зээлийн хүүг ч мөн үүнд хамааруулан авч үзэхэд шүү дээ. Ломбардын хүү сарын 5-6 хувь гэж тооцвол жилийн 60-70 хувь болж байна. Иймэрхүү төрлийн зээлийн хүүн дээр тааз тогтоогоод хүчээр шийдэж болохоор юм шиг харагдаж байж болно. Гэхдээ амьдралд яг тийм зүйл болоход хэцүү. Тухайлбал, банкинд байгаа санхүүгийн эх үүсвэр хязгаартай. Банк бол санхүүгийн зуучлагч. Хэчнээн хүн банкинд хадгаламж, харилцахаа байршуулж байна, тэр хэмжээгээр зээл болгож гаргадаг. Энэ нь өөрөө олон улсын зарчим, стандартаар бий болсон харьцааны шалгуур үзүүлэлттэй явдаг бизнес. Тэгэхээр банк 10 зээлдэгч байлаа гэхэд хамгийн сайн 5-д нь л зээлээ өгөөд, үлдсэн 5-д нь зээл өгч чадахгүй. Яагаад гэвэл эх үүсвэр хязгаарлагдмал шүү дээ. Тэгэхээр үлдсэн 5 нь хаашаа явах вэ гэхээр банк бус санхүүгийн байгууллага, эсвэл хадгаламж зээлийн хоршоо, бүр цаашилбал ломбард, ломбард байхгүй бол хувь иргэд хоорондын зээл хүртэл явна. Тэгэхээр санхүүгийн зах зээлийг тогтвортой хөгжүүлж, томруулах юм бол 1000 хувийн

хүүтэй зээл авах гэж байсан хүмүүст наашлах нөхцөл бүрдэнэ. Банкны зээлийн хүү 15 хувь байгааг өндөр байна, үүнийгээ 12 болго гэж хүчээр тогтоовол юу болох вэ гэвэл чанаргүй зээл л нэмэгдэнэ. Өнөөдөр банкны нийт олгосон зээл 17 их наяд төгрөг байгаагаас 10 хувь нь буюу 1.7 их наяд төгрөг нь чанаргүй болчихсон байна. Энэ зээл төлөгдөхгүй байгаа учраас банк шинэ зээлдэгчид тэр бүр зээл олгож чадахгүй байна. Дээрээс нь эрсдэлтэй зээлдэгчдэд банк үргэлж болгоомжтой ханддаг. Тэгэхээр эх үүсвэрийн хүүн дээрээ эрсдэлээ тооцоод, зардлын маржинаа нэмээд, зээлийн хүү тогтож байгаа. Гэтэл эрсдэлийг нь “Чи үүнийг эрсдэл гэж битгий тооц” гээд хүчээр хасуулж байгаатай адилхан. Энэ тохиолдолд банк зээл өгөхгүй байсан нь дээр гэдэг нэг л сонголттой болох гээд байгаа юм. Тэгэхээр аль болох банкны хувьд тулгарч буй эрсдэлүүдээ багасгах ёстой. Дээр нь илүү ил тод байж, санхүүгийн зуучлалын зарчмаар явж, аажимдаа нөлөөлөх замаар зээлийн хүүг бууруулах ёстой гэж төв банк үзэж байна. Түүнээс биш 1000 хувийн хүүтэй зээл авч байгаа хүнийг аль нэг банкинд авчраад “Чи одоо эндээс зээл ав”, харин банкныг “Чи энэ хүнд зээл өг” гэж шахаж болохгүй. Тиймээс санхүүгийн зах зээлийн өрөөсгөл бүтцийг хэрхэн тэнцвэртэй хөгжүүлэх вэ. Тухайлбал, зээл авсан аж ахуйн нэгж зээлээ даатгуулчихвал, тухайн бизнес хүндэрсэн тохиолдолд даатгалын

байгууллага ном журмынхаа дагуу ажиллаж, хохирлыг барагдуулах учиртай. Ийм л систем ажиллах хэрэгтэй байна. Үүний төлөө хууль эрх зүйн орчны шинэчлэлийг хийж, тогтолцоог нь сайжруулахад Монголбанк анхаарч ажиллаж байна.

Стандартын тухай Та ярьлаа. Энэ нь одоо бидний ярих сэдэвтэй хамааралтай гэж үзэж байна. Одоо бол иргэд зарим талаар ипотекийн зээлийн хүү өндөр байна гэж гомдоллох болжээ. Гэхдээ энэ 10 дугаар сард ипотекийн зээлийн хүүг 6 хувь болгосон нь нэг талаас барилгын салбар, нөгөө талаас иргэдэд маш том итгэл төрүүлсэн үйл явдал боллоо. Энэ арга хэмжээний ард талд юу байсан бэ, хэр зэрэг өргөн далайцтайгаар цааш үргэлжлэх бол?

- Монголбанк ипотекийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Дэлхийн бусад улсуудын жишгийг харвал төв банк үүнийг хэрэгжүүлдэггүй. Энэ бол Засгийн газар, эсвэл Засгийн газрын харьяа агентлагийн зүгээс хэрэгжүүлдэг төрийн зохицуулалттай хөтөлбөр. Өнөөдөр банкны зээлийн дундаж хүү 15 хувь. Ипотекийн зээлийн хүү 6 хувь. Энэ хооронд бүхэл бүтэн 9 хувийн зөрүү байна. Гэхдээ хөтөлбөр учраас хөтөлбөрийн зохицуулалтаараа хэрэгжиж байна. Ингээд харахаар хүчээр хийж байгаа юм шиг харагдаж байж болох. Гэхдээ Монголбанк 8 байсан хүүг 6 болгож



бууруулсан нь санааныхаа зоргоор хийсэн зүйл биш юм. Бүгдийг тооцоолж, судалсан. Монголбанк өнөөдрийг хүртэл 8 хувийн хөтөлбөр хэрэгжүүлсэн нь мөн л тооцоо, судалгаатай бодлогын шийдвэрүүд дээр хэрэгжсэн. Энэ бүгд ерөөс буруу шийдвэр байгаагүйг 2011 оноос өнөөдрийг хүртэл тогтвортой үргэлжилж байгаагаар дүгнэж болно. Өнөөдрийн 6 хувийн хөтөлбөрийн хувьд Монголбанк өмнөх шигээ дангаараа бус хамтын санхүүжилттэй болж Засгийн газар, банкуудын оролцоотой хэрэгжүүлж байна. Өмнө нь 100 хувь Монголбанкны эх үүсвэрээр санхүүждэг байсан бол аажимдаа Монголбанк, банк тус бүртээ 50 хувиар санхүүжилтийг шийдвэрлэх болсон. Харин одоо 6 хувь болсонтой холбоотойгоор Монголбанкны оролцоо бага зэрэг нэмэгдэж, 60/40 гэсэн харьцаатай болсон. Ипотекийн зээлийг өнөөдөр 99 мянга

гаруй иргэн авч, зээлийн хэмжээ 4 их наяд гаруй төгрөгт хүрсэн байна. Энэ төрлийн зээлийн хувьд чанаргүйдсэн үзүүлэлт нь ердөө 1 хувь байна. Олон улсын жишгээр ипотекийн зээлийн хувьд чанаргүй зээлийн үзүүлэлт нь 1-2 хувь л байдаг. Бидний хувьд 1 хувь байна гэдэг нь дэлхийн жишигтэй адилхан. Тэгэхээр эрсдэл маш бага байхаар байна. Бид эрсдэлд зориулаад нөөц сан байгуулаад явж байсан. Үүнээс харахад 8 хувийн хүүнийхээ 1 хувийг төвлөрүүлж байсан бол одоо нөөц санг томруулж, байгуулах шаардлагагүй гэж үзсэн. Ер нь бол эрсдэл маш бага байна гэдгийг нэгдүгээрт харсан. Хоёрдугаарт, өнөөдөр бодлогын хүү 6 хувь болсон нь төгрөгийн зах зээлийн хүүний голч гэж хэлж болно. Тэгэхээр бодлогын хүү 6, ипотекийн хүү 6 хувь байна гэдэг нь ипотекийн зээлийн хүү зах зээлийн хүүнээс зөрүүгүй гэдгийг

харуулж байна. Үүнээс олон улсын аргачлалаар нь харвал ипотекийн зээлийн хүү нь хөнгөлөлттэй, татаастай хүү биш юм байна гэдгийг харж болно. Олон улсын байгууллагууд Монголбанкийг зах зээлийн хүүнээс бага хүүгээр зээл олгож байгаа нь алдагдал бий болгож байна гэж шүүмжилдэг. Төв банкны алдагдал төсвөөр нөхөгдөх ёстой учраас төв банк алдагдалтай бизнес хийх нь төсвийн шинжтэй үйл ажиллагаа явуулж байна гэдэг. Гэтэл одоогоор бодлогын хүү ипотекийн зээлийн хүүтэй адилхан болчихсон учраас тэнд алдагдал гарах зүйл байхгүйгээс гадна төсвийн шинжтэй арга хэмжээ мөн, биш гэдэг дээр тодорхой шийдэл болж чадахаар байна. Үүнээс гадна монголчуудын хувьд 6 хувийн хүүг бас л өндөр байна гэдэг. Гэхдээ энэ бол өндөр хүү биш. Өөрөөр хэлбэл төгрөгөөр олгогдож байгаа зээлийн хувьд хүү харин ч бага талдаа. Энэ төрлийн зээлийн олон улс дахь туршлагыг харуулсан судалгаанаас үзэхэд АНУ-д ипотекийн зээлийн хөтөлбөрийг "Fennie May", "Freddy Mc" гээд төрийн өмчит хоёр байгууллагаар хэрэгжүүлдэг. 2008 онд эдгээр байгууллагын ипотекийн зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор эдийн засгийн хямрал үүссэн. Эндээс өгсүүлээд бүхий л сургамжуудыг Монголбанк харж, судалж байна. Их Британи болон бусад хамтын ажиллагаатай улс орнууд Австрали, Шинэ Зеландад ипотекийн зээлийн хүү 4.5-

5 орчим хувь байдаг. Энэ нь манай 6 хувийн хүүтэй дөхүү байна. Гэхдээ Их Британийн паунд ямар хүчтэй мөнгө гэдгийг бодоход илүүдэхгүй. Австрали, Шинэ Зеландын мөнгө бас л хүчтэй. Эдгээр хүчтэй мөнгөөр авсан 5 хувийн хүүтэй зээлийг төгрөгийн 6 хувийн хүүний зардалтай харьцуулахад маш өндөр зардал гарна. Тэгэхээр мөнгөний худалдан авах чадвараар нь харвал манай 6 хувийн хүүтэй зээл бол маш хямд гэж Монголбанк үзэж байна. Гэхдээ 6-аас доош буух орон зай маш бага. Яагаад гэвэл төгрөг өөрөө тодорхой өгөөжтэй байх ёстой. Түүнээс доошилбол, төгрөгийн үнэ цэнийг алдагдуулна.

Зээлийн хүүгийн түвшин буурч байна. Гэхдээ энэ жил цар тахлаас үүдэлтэй зээлийн төлөлтүүдийг хойшлуулсан. Энэ нь системийн хувьд авч үзвэл хэр зэрэг эрсдэлтэй вэ?

- Олон улсад мөрддөг Базелийн хорооны зарчим, Базелын хяналт, шалгалтын стандарт гэж бий. Дэлхийн бүх банк энэ стандартыг мөрддөг. Тэгэхээр Базелийн хорооны хувьд ковидтой холбоотойгоор хяналт, шалгалтын хатуу стандартуудаа тодорхой хэмжээгээр буулгасан. Түүнтэй адилхан Монгол Улс ч мөн хяналт, шалгалтын зарим стандартаа бууруулсан. Тэгэхээр зээл авсан хүн зээлийн хугацаагаа сунгая гэвэл журмаараа нэг удаа л сунгах боломжтой. Хэрэв хоёр дахь удаагаа сунгавал үнэхээр энэ хүний бизнес муудаж

байгаа учраас зээл төлөгдөх магадлал нь буурч байна гэж үзээд, зээлийн мэдээллийн санд муу зээл гэж бүртгэгддэг. Мөн банкин дээр эрсдэлийн сан байгуулах гэх зэргээр ачаалал үүрч эхэлдэг. Тэгэхээр бид Засгийн газартай зөвшилцөж, 4-р сард хугацааг нь сунгаж болно гэдэг шийдлийг гаргаж ирсэн. Мөн сүүлд 10 дугаар сард энэ арга хэмжээг 7 дугаар сарын 1 хүртэл сунгаж болно гэдэг шийдвэрийг гаргасан. Тэгэхээр зээлдэгчид үнэхээр хүндрэл учирсан бол банктайгаа зөвшилцөн, зээлийн гэрээндээ өөрчлөлт оруулж болно. Өмнө нь нэг удаа сунгасан бол хоёр дахь удаагаа сунгах боломжийг сүүлийн зохицуулалтаар олгосон. Долоодугаар сарын 1 хүртэл зээлийнхээ хугацааг сунгаж болно гэсэн үг. Үндсэн өрөө төлөхгүйгээр хойшлуулж болно, бас зээлийнхээ хүүг ч төлөхгүйгээр хойшлуулж болно. Гэхдээ энэ хооронд эх үүсвэр буюу хадгаламж дээр хүү тооцогдож байгаа учраас зээл дээр нь хүү нэмж бодогдоно гэж шийдвэрлэсэн. Банкууд янз бүрээр л шийдэж байна. Үүнийг нэгдсэн байдлаар тэдэн хувиар хөнгөл, эсвэл битгий хүү ав гэж зохицуулж болохгүй. Яагаад гэвэл энэ бүгд гэрээний үндсэн дээр зохицуулагдаж байгаа харилцаа шүү дээ. Гэхдээ энэ хэмжээгээр хойшлуулж байгаа учраас тодорхой хэмжээний дарамт банкинд үүсч байгаа.

Бид сар болгон банкны тайланг авч үздэг. Эндээс банкууд 2018, 2019 онд нэлээд өндөр буюу 200-300 тэрбум төгрөгийн

ашигтай ажиллаж байсан бол 2020 онд ерөнхийдөө 20-50 тэрбум төгрөгийн л орлоготой ажиллах дүр зураг харагдаж байна. Тэгэхээр банкууд орлого олох боломжоо алдаж байна. Монголбанкны зүгээс ковидтой холбоотойгоор энэ нөхцөл байдлыг дүгнэж байгаа ч эргээд эдийн засаг сэргэх үед банк бэлэн байх ёстой. Эдийн засгийн идэвхжил сэргэхэд бүгд л зээл авах гээд эхэлнэ. Тэр үед зээл олгох санхүүжилтийн эх үүсвэр, нөөц хангалттай байх ёстой. Тийм учраас Монголбанк энэ асуудлыг анхаарахаас өөр аргагүй.

2021 оны хувьд бүх зүйл өөдрөг байгаасай гэдэг хүлээлт бий. Гэхдээ хөл хорионы арга барил тодорхой хэмжээнд үргэлжлэх байх. Мэдээж хөдөлгөөн багасах тусам эдийн засгийн цусны эргэлт муудна. Цаашид 2021 онд эдийн засгаа зогсоочихгүйн тулд яах ёстой вэ. Магадгүй вирустэйгээ дасан зохицоод явах ёстой юу. Эсвэл вакцинжуулж аюулгүй болох хүртэл ер нь ямар арга зам бидэнд байна вэ?

- Эдийн засгийн тоон үзүүлэлт ямар нэгэн юмны илэрхийлэл байдаг. Монголбанк их олон үзүүлэлтүүдийг тооцож байдаг. Мөнгөний эргэлтийн хурд гэж үзүүлэлт бий. Эдийн засагт 100 төгрөг нийлүүлэхэд хэр хурдан, хэдэн удаа эргэлдсэнээр буцаж төв банкиндаа ирдэг вэ гэдгийг харуулдаг үзүүлэлт юм. 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт бараг хоёр дахин

нэмэгдсэн. 2016 оны эцэст 12 орчим их наяд төгрөг байсан бол одоо 21 их наяд төгрөг болж, бараг хоёр дахин өсчээ. Тэр үеийн эдийн засгийн мөнгөний эргэлтийн хурдыг авч үзвэл ялангуяа эдийн засаг идэвхжиж байсан 2017, 2018 онд 2 хувь руу дөхөж байв. Өнөөдөр 1.7 хувьтай байгаа нь бүтэн 2 эргэж чадахгүйгээр, ерөнхийдөө гацсан байдалтай байна. Эдийн засгийн амьд харилцаа байхгүй болж, бизнес гацах тусмаа мөнгөний эргэлтийг удаашруулж байна гэсэн үг. Тийм учраас энэхүү цар тахлын голомтыг аль болох хурдан цурманд оруулж, барьж тогтоох нь нэн тэргүүний зорилт учраас нөхцөл байдалтай эвлэрэхээс өөр арга алга. Гэхдээ үүний хажуугаар яаж эдийн засгийг идэвхжүүлэх вэ гэдэг нь чухал. Ийм үед бид банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг аль болох бүрэн цахимжуулахад анхаарч байна. Төлбөр тооцооны хувьд өнгөрсөн хугацаанд нэг их унасангүй. Эдийн засгийн харилцаа ямар ч байсан тодорхой хэмжээнд зогсчихоогүй байна.

Монголбанк төлбөр тооцоог зохицуулж байна. Их, бага дүнтэй болон картын гүйлгээний хувьд бүгд өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага зэрэг буурсан. Гэхдээ эхний хагас жилийн дүнтэйгээ ижил түвшинд байгаа нь боломжийн дүн. Гэсэн ч энэ хэмжээгээрээ удаан явна гэвэл их төвөгтэй. Тийм учраас эдийн засаг буцаж хэвэндээ орох зайлшгүй шаардлагатай.

Монгол Улсад вакцин хэзээ орж ирэх нь тодорхойгүй байна. Гэхдээ Хятад, Америк, Орос, Европын холбоо иргэдээ вакцинжуулаад эхэлсэн. Эдгээр улсад эдийн засаг хэвийн түвшин рүүгээ шилжих байх. Энэ утгаараа манай гадаад орчин хэвийн болоод эхэлбэл, манай эдийн засаг тодорхой хэмжээнд идэвхжих нь ойлгомжтой. Манай улсын хувьд экспорт хилийн хорио, цээргүйгээр гараад эхэлбэл тун сайн байна. Мэдээж вакцин орж ирснээр бүх зүйл аажмаар хэвийн түвшиндөө очих ёстой. Тэр утгаараа бид ирэх онд Монгол Улсын эдийн засгийг 5-6 хувиар өснө гэж төсөөлж байна. Ялангуяа өнөөдрийнхөө байдлаас дордохгүй бол энэ хэмжээгээ хадгалах боломжтой. Бидний энэхүү төсөөлөл нь өнөөдрийн түвшинд хамгийн тааруу байгаа хүчин зүйлс дээр тулгуурлаж тооцоолсон төсөөлөл. Үүнээс муудвал мэдээж өсөлт муудах байх. Гэхдээ үүнээс муудахгүйгээр, дээр нь илүү сайн тал руугаа өөрчлөгдвөл эдийн засаг маань бүр ч огцом өсөх боломжтой юм.

Мэдээж сайхан ирээдүйг бид хүлээж байна. Энэ боломж ирнэ гэдэгт итгэж байна. Бидэнд цаг гаргаж ярилцсанд баярлалаа.

Эх сурвалж: Блүүмбэрг ТВ

БОДЛОГЫН ХҮҮГ БУУРУУЛЖ, РЕПО САНХҮҮЖИЛТИЙГ НЭВТРҮҮЛСЭН НЬ ЭДИЙН ЗАСАГТ ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?

2020 оны 11 дүгээр сард Мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурлаас бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж, 6 хувьд хүргэх шийдвэр гаргасан. Мөн зах зээлд урт хугацаатай репо санхүүжилтийг нэвтрүүлснээр жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарыг дэмжихийг зорьж буй билээ. Тэгвэл Төв банкны эдгээр бодлогын арга хэмжээний талаар эдийн засагчид дараах байр суурьтай байна.



Монголбанкны
Мөнгөний бодлогын
хорооны гишүүн

Ч.ХАШЧУЛУУН

Монголбанкнаас Ковид-19-тэй холбогдуулан бодлогын арга хэмжээг шуурхай авсан. Тухайлбал, бодлогын хүүг бууруулахын зэрэгцээ банкуудын заавал байлгах нөөцийг багасгасан. Мөн жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжих репо санхүүжилтийг бий болгож, 2020 оны дөрөвдүгээр улирал, 2021 оны 1 дүгээр улиралд нийтдээ 480 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор болсон. Эндээс үйлдвэрүүд эхний байдлаар санхүүжилтээ авсан гэсэн мэдээ бий. Тодруулбал, 2020 оны 4 дүгээр улиралд нийтдээ 230 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг шийдсэн байсан. Энэ санхүүжилтийн бараг 50 хувь нь 12 дугаар сарын 15-ны байдлаар үйлдвэрүүдэд очсон гэсэн мэдээг бид авсан. Мөн цаашдаа санхүүжилт авъя гэсэн хүсэлтүүд нэлээд их байна. Нийтдээ 400 орчим тэрбум төгрөгийн хүсэлт ирсэн.

Тэгэхээр Монголбанкнаас бараг 480 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад нийлүүлж байгаа учраас хүсэлтүүд бүрэн дүүрэн хангагдах боломжтой. Ингэснээр үйлдвэрүүд зардлаа бууруулах, зээлийн хүүгээ бууруулснаар үйл ажиллагаагаа сэргээх алхмуудаа хийж байгаа юм билээ. Ер нь репо санхүүжилтийн хувьд эдийн засагт хоёр үүргийг гүйцэтгэж байна. Нэгдүгээрт, хямралын үед эдийн засгийг тогтворжуулах, үйлдвэрүүдийг сэргээхэд тус болж байгаа. Хоёрдугаарт, урт хугацааны бүтцийн өөрчлөлтийг дэмжиж байгаагаараа онцлогтой. Манай эдийн засаг бүтцээ шинэчлэх, өөрчлөх цаг болсон. Ялангуяа хөл хорионы үед дотооддоо үйлдвэрээ хөгжүүлэх нь асар чухал гэдэг нь харагдсан. Хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо 100 хувь хангах, голлох барилгын материалууд, хувцас хэрэглээ, эм, эмнэлгийн энгийн хэрэглэл, эмчилгээний хувцас зэргийг дотооддоо үйлдвэрлэх нь асар чухал болоод байна. Тийм учраас репо санхүүжилтээр дамжуулан эдгээр үйлдвэрлэлийг дэмжих хэрэгтэй болов уу.



"Мандал даатгал"
ХХК-ийн Хөрөнгө оруулалт
хариуцсан захирал

Г.ГАНЗОРИГ

Бодлогын хүүг бууруулах нь зээлээр дамжин зах зээлд нөлөөлж бодит эдийн засагт дэмжлэг болдог. Гэтэл яг одоо цагт хөл хорио гээд бизнесүүдийн үйл ажиллагаа хэвийн явахгүй байгаа нь зээлийн эрэлтийг эрс бууруулсан байдалтай байна. Тэгэхээр өнөөгийн нөхцөлд бодлогын хүүний бууралт нь хуучин шигээ зах зээлд нөлөөлж чадахгүй. Энгийн үед ч бодит эдийн засаг дахь бодлогын хүүний нөлөө нь хэсэг хугацааны дараа гардаг, харин энэ удаад тэрхүү хугацаа нь улам бүр хойшилж байх шиг байна. Харин репо санхүүжилтын хувьд эдийн засгийн хүндрэлтэй үед тун ч тохиромжтой алхам болсон гэж харж байгаа. Эдийн засгийн хүндрэлтэй үед ийнхүү зах зээлд мөнгө нийлүүлэх нь зайлшгүй шаардлагатай байсан. Олон улсад ч гэсэн их хэмжээний мөнгийг зах зээлд нийлүүлсээр байгаа. Манай улсын хувьд харин ч багадсан уу гэхээс ихдээгүй. 12 дугаар сард гарсан мэдээллийн дагуу нийт 230 тэрбум төгрөгийг репо санхүүжилтийн хүрээнд олгосон байсан.

Ийнхүү шалгуур хангаж буй аж ахуйн нэгжүүд зээлийн хүүг 10.5 хувиас хэтрэхгүй байхаар бууруулж, үндсэн төлбөрөөс 6 сараас багагүй хугацаанд чөлөөлөгдөх боломжтой болсон. Сайн хэрэг, зөв ахлам. Гэхдээ хангалттай биш. Өнөөгийн нөхцөл байдалд үүнээс ч илүү зоригтой алхамууд удирдах байгууллагууд хийх шаардлагатай байна. Мэдээж эдгээр нь урт хугацаанд валютын ханш болон инфляцид дарамт болох эрсдэлтэй. Гэвч энэ нь бидний одоо санаа зовох ёстой асуудал биш. Би яагаад ханш бол одоо санах зовох ёстой асуудал биш гэж байна гэхээр богино хугацаанд манай гадаад худалдааны тэнцэл сайн ашигтай хэвээр байна. Түүнчлэн бидэнд тодорхой валютын нөөц ч байна. Одоо бол ерөөсөө л Stagflation болгохгүй байх нөхцөлийг эрэлхийлэх учиртай. Санаа нь инфляци өндөр мөртлөө, эдийн засгийн өсөлтгүй байх үе шүү дээ. Тэгэхээр нэг талдаа зах зээлд мөнгө нийлүүлэх нь зөв, гэхдээ нөгөө талдаа тэр нь бодит эдийн засгийн өсөлт биш зөвхөн хоосон инфляци болчихвол яах вэ л гэдэг асуудалд санаа зовох шаардлагатай.



Эдийн засгийн бодлого,
өрсөлдөх чадварын
судалгааны төвийн захирал,
эдийн засагч

Б.ЛАКШМИ

Ер нь төв банкнаас авч байгаа арга хэмжээнүүд цогцоороо эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг сайжруулах, мөнгөний олдоцыг нэмэгдүүлэх л зорилготой байгаа. Тухайлбал, бодлогын хүүг бууруулахаас гадна банкуудын заавал байлгах нөөцийн шаардлагыг бууруулсан. Мөн репо санхүүжилтийг нэвтрүүлсэн зэрэг нь эцсийн дүндээ эдийн засаг дахь мөнгөний эх үүсвэрийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Гэхдээ репо санхүүжилт нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хүндэрч, зээл авахад хүндрэлтэй, зээлийн шалгуур өндөрссөн үед харьцангуй хямд бөгөөд урт хугацаатай эх үүсвэр болж байгаа гэдгээрээ онцлогтой. Зөвхөн банкны зээлээс гадна нэмэлтээр санхүүжилтийн эх үүсвэр олж авах шинэ боломжийг бий болгох арга хэрэгсэл юм. Дэлхий нийтээр эдийн засаг, санхүүгийн томоохон хямралд орж байсан 2007, 2008 онуудад дэлхийн бусад улс оронд ч бас репо санхүүжилт буюу түүнтэй төстэй бодлогын арга хэмжээнүүдийг авч, үр дүнд хүрч байсан юм билээ.

Мэдээж эдгээр арга хэмжээнүүд нь эдийн засгаа сэргээхэд чухал нөлөөтэй. Гэхдээ эдийн засгийг хөл дээр нь босгоход зөвхөн төв банк дангаараа ажилладаг гэж ойлгож болохгүй. Засгийн газрын хувьд төсвийн оновчтой бодлого явуулж, эдийн засгийн хүндрэл, хямралын үед шаардлагагүй зардлуудаа танах зэргээр төсвөө тодотгох шаардлагатай. Ингэснээр төсвийн бодлого нь мөнгөний бодлоготой харилцан нийцтэй хэрэгжих юм. Хэдийгээр эдийн засаг 2020 оны эхэн, дунд үеийг бодоход харьцангуй сэргэж байгаа ч гэсэн эрсдэл байсаар байна. Энэ эрсдэл хэрвээ илүү ихээр нэмэгдвэл төв банкнаас өнөөдрийг хүртэл авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийн үр нөлөөг саармагжуулна. Тэгэхээр мөнгөний бодлогоос гадна төсвийн зөв зохистой бодлогоор эрсдэлийг аль болох бууруулах алхам хийж байх нь маш чухал.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Бодлогын хүү, заавал байлгах нөөцийн хувийг бууруулах, хэрэглээний зээлийн хугацааг сунгах, урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх тухай

Дугаар: 2020/06

Огноо: 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо КОВИД-19 цар тахал дотоодод тархаж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосонтой холбоотойгоор 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ээлжит бусаар хуралдлаа. Энэхүү хуралдаанаар:

1. Бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх;
2. Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд тогтоох;
3. Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
4. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг багц шийдвэрийг гаргалаа.

Энэ нь КОВИД-19 цар тахлын үед эдийн засаг, банк, санхүүгийн салбарт үүсч буй сөрөг нөлөөг бууруулах, иргэд, бизнес эрхлэгчид, санхүүгийн байгууллагуудад тулгарч буй санхүүгийн хүндрэл дарамтыг зөөлрүүлэхэд чиглэж байна. Түүнчлэн дунд хугацаанд инфляцын зорилтыг алдагдуулахгүйгээр санхүүгийн болон эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжинэ.

Жилийн инфляц 2020 оны 10 дугаар сард улсын хэмжээнд 2.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 2.6 хувьд хүрэв. Ирэх саруудад инфляц суурь үеийн нөлөөгөөр бага зэрэг нэмэгдэх хэдий ч, эдийн засгийн идэвхжлээс шалтгаалан бага түвшинд хадгалагдаж зорилтот түвшнээс давахааргүй байна. Эдийн засаг “КОВИД-19” цар тахлын нөлөөгөөр 2020 оны эхний хагаст 9.7 хувиар агшсан бол 3-р улиралд уналт -3.1% болон саармагжиж, төлбөрийн тэнцлийн төсөөлөл сайжрав. Цар тахлын дотоод тархалтыг хумихаар 11-р сард тогтоосон хөл хорионы арга хэмжээнүүд нийгмийн эрүүл мэндийг хамгаалж, дунд урт хугацаанд эерэг нөлөөтэй боловч богино хугацаанд эдийн засгийн үйл ажиллагааг хумьснаар сэргэлт удаашрах төлөвтэй байна.

Дэлхийн эдийн засгийн идэвхжил 2020 оны сүүлийн хагаст сэргэж буйг бодит эдийн засаг, санхүүгийн зах зээл, түүхий эдийн захын үзүүлэлтүүд илэрхийлж байна. Эхний вакцинуудын амжилттай туршигдан дуусах шатандаа орж буй хэдий ч цөөнгүй улс оронд вирусийн хоёр дахь болон гурав дахь давалгаа үргэлжилж, эдийн засгийн цаашдын төлөвийн тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

“КОВИД-19” цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор шат дараатай авч хэрэгжүүлж буй мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүд нь жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын санхүүжилтийг нэмэгдүүлж, санхүүжилтийн өртгийг бууруулан дотоод эдийн засгийн уналтыг сааруулах, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлнэ. Монголбанк нь өрхийн болон аж ахуйн нэгжийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихийн зэрэгцээ банкны системийн зээлийн тасалдал үүсэхээс сэргийлсэн зохистой арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулах болно.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



**ТӨРӨӨС
ХЭРЭГЖҮҮЛЖ
БУЙ ИПОТЕКИЙН
ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ЗЭЭЛИЙН
ТӨЛБӨРИЙГ
ХОЙШЛУУЛАХТАЙ
ХОЛБООТОЙ
ТҮГЭЭМЭЛ
АСУУЛТ,
ХАРИУЛТ**

✓ **Ямар зээлдэгч хамрагдах вэ?**

8, 6 болон 5 хувийн хүүтэй ипотекийн зээлтэй иргэд хамрагдана.

✓ **Зээлдэгч хэдэн удаа төлбөрөө хойшлуулж болох вэ?**

Заасан хугацаанд нэг л удаа.

✓ **Зээл хойшлуулснаар зээлийн ангилалд өөрчлөлт орох уу?**

Зээлийн ангилалд өөрчлөлт орохгүй.

✓ **Нотариатаар баталгаажуулах шаардлагатай юу?**

Зээлдэгчид эрсдэлгүйгээр банкин дээр үйлчлүүлэх боломжтой болсон үед зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, нотариатаар баталгаажуулна.

✓ **Хүсэлт гаргаагүй зээлдэгчдийн хувьд төлбөрийг яах вэ?**

Хүсэлт гаргаагүй ч, төлөгдөхгүй байгаа зээл холбогдох гэрээ, журам, хуулийн дагуу зохицуулагдах болно.

✓ **6 сараар хойшлуулж байсан зээлдэгч төлбөрөө дахин хойшлуулах боломжтой юу?**

Хөнгөлөлттэй нөхцөлтэй ипотекийн зээлтэй бүх зээлдэгч төлбөрөө хойшлуулах боломжтой.

✓ **Зээлийн хойшлуулсан хугацаанд хүү төлөх үү?**

Энэ хугацаанд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөхгүй, хуваарийг уртасгана. Гэхдээ амь нас, эд хөрөнгийн даатгалыг төлнө.

✓ **Хэрхэн хамрагдах вэ?**

2021.01.30-ны дотор зайнаас хүсэлт гаргана. 2021.07.01-ний өдрийг хүртэл хойшлуулна.

✓ **Өмнө нь доголдол үүссэнтэй холбогдуулан ногдуулаад байсан нэмэгдүүлсэн хүүг банкууд харилцагчдаа буцаан олгох уу?**

Зээлийн доголдолд ногдуулаад байсан нэмэгдүүлсэн хүү, алданги хэвээр үлдэнэ.

✓ **Ямар баримт бичиг, нотолгоо бүрдүүлэх шаардлагатай вэ?**

Зөвхөн цахим хуудас, имэйл, мобайл апликайшн, утас зэргээр хүсэлт гаргахад болно.

✓ **Өр, орлогын харьцаа зэрэг зохицуулалтуудыг мөрдүүлэх үү? Сард төлдөг зээлийн төлбөр өөрчлөгдөх үү?**

Өр, орлогын харьцаа, хугацааны хязгаар зэрэг зохицуулалтуудаас түр чөлөөлнө.

✓ **Сард төлдөг зээлийн төлбөр өөрчлөгдөх үү?**

Зохицуулалт хэрэгжиж дууссанаар сард төлдөг байсан зээлийн төлбөрт өөрчлөлт орохгүй.

✓ **Хүсэлт гаргах хүртэл зээлийн төлбөрөө төлөх үү?**

Банкинд хүсэлт гаргах хүртэл зээлийн төлбөрийг хуваарийн дагуу төлнө.

✓ **Хугацаа хэтэрсэн зээлдэгчийн хувьд төлбөрөө хойшлуулж болох уу?**

Эдгээр иргэд банкиндаа хүсэлт гаргаснаар зээлийн төлбөрөө хойшлуулж болно.

✓ **Зээлдэгчид ямар дэмжлэг үзүүлж байгаа вэ?**

Өрхийн орлогыг дэмжих, худалдан авах чадварыг хамгаалахад дэмжлэг үзүүлнэ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭНТЭЙ ХОЛБООТОЙ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

✓ **Хэрэглээний бүх зээлийн хугацааг 12 сараар сунгах боломжтой юу?**

Үгүй. Зөвхөн эргэн төлөлтөд хүндрэл учирсан хэрэглээний зээлийг сунгах боломжтой.

✓ **12 сараас урт хугацаагаар сунгах боломжтой юу?**

Зөвхөн Монголбанкнаас тогтоосон хугацаа (30 сар) болон өр, орлогын харьцааны (60 хувь) хязгаарлалтын хүрээнд 1 удаа сунгах боломжтой.

✓ **Энэ удаагийн шийдвэр хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ?**

2020.11.23-ны өдрийн Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр 2021.07.01 өдрийг хүртэл хэрэгжинэ.

✓ **Хэрэглээний зээлд ямар төрлийн зээлийн бүтээгдэхүүнүүд багтдаг вэ?**

Цалин, тэтгэврийн зээл болон малчны зээл зэрэг өрх гэр, иргэдийн зээлийн бүтээгдэхүүнийг хэрэглээний зээл гэж ойлгож болно.

✓ **Зээлийн өөрчлөлт нөхцөлд оруулж, хугацааг сунгахад ямар материал бүрдүүлэх вэ?**

Орлого тасалдаж, зээлийн эргэн төлөлтийг хийхэд хүндрэл учирсан зээлдэгчид банкинд хүсэлтээ гарган нөхцөлөө өөрчлөх боломжтой.

✓ **Зээлдэгчийн өр, орлогын харьцаанд өөрчлөлт орох уу?**

Тийм. Учир нь зээлдэгч зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулах бүрт өр, орлогын харьцааны тооцооллыг шинэчлэх шаардлагатай байдаг.

✓ **Зээлдэгч зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд заавал 12 сараар зээлийн хугацааг сунгах уу?**

Үгүй. Зээлдэгч нь банктайгаа тохиролцож зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах боломжтой бөгөөд 12 сар хүртэлх хугацаагаар зээлийн үлдэгдэл хугацааг сунгаж болно.

✓ **Өр, орлогын харьцаа нь 60 хувиас өндөр байгаа зээлүүдийн хувьд хугацааг сунгаж болох уу?**

Болно. Өмнө нь өндөр өр орлогын харьцаагаар авсан зээлүүдийг 12 сараар сунгасан ч өр орлогын харьцаа нь 60 хувиас давах тохиолдол гарахыг үгүйсгэхгүй.

✓ **Өрхийн гишүүн нь түр хугацаанд ажилгүй, орлогогүй болсон тохиолдолд хамрагдах боломжтой юу?**

Боломжтой. Гэхдээ зээлдэгч нь, ажилгүй эсвэл орлого тасалдсан иргэнийг өөрийн өрхийн гишүүн, мөн өрхийн гишүүн нь орлого тасалдсан гэдгийг нотлох шаардлагатай.

✓ **Зээлийн хугацааг сунгахад зээлийн үлдэгдэл дүнд өөрчлөлт орох уу?**

Зээлдэгч зээлийн хүүний төлбөрийг төлөхгүйгээр хойшлуулсан тохиолдолд хуримтлагдсан хүүний төлбөрийг үлдэгдэл хугацаанд тархаан байршуулах (хүүг капиталжуулах) дүнгээр өсч болно. Бусад тохиолдолд өөрчлөлт орохгүй.

✓ **Өмнө нь зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан зээлдэгчид хэрэглээний зээлийн хугацааг дахин сунгах боломжтой юу?**

Тийм. Өмнө нь зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан эсэхээс үл хамаарч хэрэглээний зээлийн үлдэгдэл хугацааг 12 хүртэлх сараар сунгах боломжтой.

✓ **Зээлийн хугацааг 12 сараар сунгахдаа хүүний төлбөрийг 3 сараар хойшлуулсан тохиолдолд нийт 15 сараар зээлийн үлдэгдэл хугацааг уртасна гэсэн үг үү?**

Үгүй. Зээлийн хугацааг сунгах нийт хугацаа 12 сараас хэтрэхгүй бөгөөд хүүг 3 сараар хойшлуулж байгаа нь 12 сардаа багтана.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурал 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргалаа.

1. Бодлогын хүүг 8 хувиас 2 нэгж хувиар бууруулж, 6 хувьд хүргэх
2. Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж, 6 хувьд хүргэх
3. Эргэн төлөлт нь доголдолд орсон хэрэглээний зээлийн бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
4. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх багц шийдвэрийг гаргав.

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг танилцуулах хэвлэлийн бага хурлын үеэр Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн асуултад хариулав.

Зээлийн хүүг бууруулах стратегийн дагуу ямар ажлууд хийгдэж байна вэ. Мөнгөний бодлогыг зөөлрүүлж, зээлийг нэмэгдүүлэх бодлогыг Монголбанк хэрэгжүүлсэн. Эдгээр бодлогын нөлөө өнөөдрийн байдлаар хэрхэн илэрч байна вэ?

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН:

Монгол Улсад анхны хорио цээрийн дэглэм нэгдүгээр сарын 27-ноос тогтоож эхэлснээс хойш Монголбанкнаас гаргасан бүхий л арга хэмжээ нь хүндрэл бэрхшээлийг зөөллөх, зохицуулалтын журмуудыг суллаж, иргэд олон нийт, аж ахуйн нэгжүүдэд ирэх дарамтыг багасгах чиглэлтэй байсан. Гуравдугаар сард болсон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар Монголбанкнаас авч хэрэгжүүлдэг активын ангилал, зээлд эрсдэлийн сан байгуулах журмын зохицуулалтыг суллаж өгсөн. Ингэснээр иргэний хэрэглээний зээл, аж ахуйн нэгжүүдийн бизнесийн зээлийн хугацааг сунгах боломжийг олгосон. Энэ зохицуулалтын хүрээнд үндсэн зээл, өрийг гэрээний дагуу хугацаандаа төлөхөөсөө илүү өдөр тутмын үйл ажиллагаа, орлогод нь гарсан хүндрэлтэй нь уялдуулж, хойшлуулж болно гэсэн

зохицуулалтын арга хэмжээ юм. Он гарснаас хойш нийт 125000 зээлдэгчийн 5.3 их наяд төгрөгийн зээл ковид-19 цар тахалд өртсөн гэсэн үндэслэлээр банкинд хүсэлтээ тавьсан. Энэ нь нийт зээлийн 33 хувийг эзэлж байсан. Тухайн үед банкууд материалыг хүлээж аваад, 3.7 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийсэн. Үүний 2.2 их наяд төгрөг нь бизнесийн зээл, 1.5 их наяд төгрөг нь иргэдийн хэрэглээний зээл байсан. Тэгэхээр энэ зохицуулалт одоо үргэлжилж байгаа. Анх зохицуулалтын шийдвэрийг гаргахдаа энэ оныг дуустал гэж гаргасан. Засгийн газрын хуралдаанд Монголбанк, СЗХ оролцоод, энэхүү арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх талаар ярилцсан. Ингээд ирэх оны 7 дугаар сарын 1 хүртэл үргэлжлэхээр болсон. Тэгэхээр зээлийн үндсэн өр, хүүг хойшлуулах арга хэмжээ үргэлжилнэ. Тэгэхээр хорио цээрийн дэглэм тогтоосон энэ үед иргэн, аж ахуйн нэгж банкиндаа цахимаар хандсанаар зээлийн төлбөрөө хойшлуулах арга хэмжээ авч болно. Өнөөдрийн гаргасан шийдвэртэй уялдуулаад, цаашдаа банкууд зээл, хүүгийн хугацааг хойшлуулахын зэрэгцээ хүүгийн хөнгөлөлт болон бусад дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг өгч байна. Яагаад гэвэл заавал байлгах нөөцийг суллаж байгаа. Жижиг, дунд үйлдвэр, уул уурхайн бус экспортод чиглэсэн аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй эх үүсвэр гаргах боломжийг төв банкнаас нээж өгч байна. Тэгэхээр энэ эх үүсвэрийг ашиглан банкууд бизнесийн зээл, хэрэглээний зээлүүддээ дэмжлэг үзүүлэх боломжтой.

Хоёрдугаарт, энэ нь хавтгайрсан арга хэмжээ байх ёсгүй. Банк болгон өөрийн гэсэн бизнесийн загвар, төлөвлөгөөтэй. Зарим банк илүү байгууллагын, томоохон зээлд илүү анхаардаг бол зарим банк хэрэглээний зээл буюу жижиглэнгийн үйл ажиллагаа явуулдаг. Тэгэхээр зээлдэгчдийнхээ зорилтот бүлэгт хамааруулаад, энэ арга хэмжээг авах боломжтой. Үүнд нь дэмжлэг үзүүлсэн шийдвэр гарч байгаа юм.

Зээлийг хойшлуулж байгаа ч энэ нь банкны хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй гэдэг талаас нь бодлогын ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН:

Өнөөдөр ковид-19 анхаарах ёстой хамгийн чухал асуудал байгаа нь үнэн. Тийм учраас хөл хорионы хатуу дэглэм тогтоож, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоож байна. Хэсэг хугацааны дараа цар

тахлыг хумьснаар бизнесийн үйл ажиллагаа сэргэнэ. Тэр үед санхүүгийн тогтвортой байдалд маш сайн анхаарах ёстой. Үүнд өнөөдрөөс бэлдэж байх ёстой юм. Тийм учраас төв банкнаас гаргаж байгаа шийдвэрүүд нь энэ бүгдийг харгалзан үзсэн. Банкны заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулсан. Мөн урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлсэн зэрэг бүхий л арга хэмжээ нь нэгдүгээрт харилцагч иргэд, аж ахуйн нэгжид дэмжлэг болно. Үүний зэрэгцээ энэ арга хэмжээг хэрэгжүүлэхдээ банк нь өөрөө хүндрэлд орохооргүй байхаар зохицуулалтыг зэрэг хэрэгжүүлж байгаа. Монголбанк удахгүй Хяналт, шалгалтын хорооны хурлаараа тодорхой зохицуулалтуудад өөрчлөлт оруулна. Мэдээж хүнд үед тодорхой хөнгөлөлт үзүүлж, дэмжлэг үзүүлэх боломжтой. Дараа нь хэвийн үед эргээд олон улсын жишиг, стандарт руугаа ороход илүү их дарамттай болох нь ойлгомжтой. Тийм учраас энэ бүгдийг бодолцсон арга хэмжээг зэрэг авч хэрэгжүүлж байгаа.

Улсын төсвийн зарлага 13.9 их наяд, алдагдал 2 их наяд гаруй төгрөг байхаар батлагдсан байгаа үед төсөв, мөнгөний бодлогын уялдаа хэр хангагдах вэ?

Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй Монголбанкны бодлого арга хэмжээ уялдах ёстой. Ковид хэнийг ч тойроогүй. Иргэн, өрх гэр, аж ахуйн нэгж, улс оронд хүртэл хүндээр тусч байгаа. Энэ утгаараа улсын төсвийн орлого маш их хэмжээгээр тасарч, алдагдал өсч байгаа. Хүүний ерөнхий түвшинг багасгасан учраас Засгийн газрын хувьд нэмэлт эх үүсвэр хэрэгтэй бол бага зардлаар авах боломж бүрдэж байна. Тэр утгаараа Засгийн газар бонд гаргаад, шаардлагатай эх үүсвэрийг санхүүжүүлэх зорилгоор эх үүсвэр босговол өнөөдрийн мөнгөний бодлогын хүүнээс ч бага хүүгээр авах боломжтой. Ийм боломж үүсч байгаа гэж харж байна. Дээр нь заавал байлгах нөөцөөс эх үүсвэр чөлөөлөгдсөн учраас эргээд Засгийн газрын болон бусад томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд дэмжлэг болно. Нөгөөтэйгүүр энэхүү шийдвэр нь зээлийн хүү буурахад ч нөлөө үзүүлнэ. Улмаар эдийн засгийг сэргээх, орлогыг нэмэгдүүлэх чиглэлд нөлөө үзүүлснээр төсөв талдаа орлогыг нэмэгдүүлэхэд дам нөлөө үзүүлэх болов уу.

ЗГ-аас авч хэрэгжүүлж байгаа 23 арга хэмжээ нь цар тахлын үед эдийн засгаа хамгаалж чадах уу? Монголбанк ямар байр суурьтай байгаа вэ?

Монголбанкны хийх ёстой ажлыг хуулиар тодорхой зааж өгсөн. Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахын төлөө ажиллана. Энэ нь инфляц болон ханшаар илэрхийлэгдэнэ. Монголбанкны мэдэгдэлд дурдсанчлан инфляцын хувьд одоогоор нийлүүлэлтийн шинжтэй инфляц байхгүй. Хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор эрэлтийн шинжтэй инфляц ч бага байгаа учраас бодлогын хүүг сулруулах орон зайг бий болгосон. Өнөөдөр бодлогын хүүг 6 хувийн түвшинд хүргэсэн нь анх бодлогын хүүг нэвтрүүлснээс хойших хамгийн бага түвшинд хүрч байна. Үүнээс цааш орон зай маш хумигдмал байгаа гэдгийг иргэд маань ойлгох байх. Энэ утгаараа Монголбанкны хувьд зоримог алхам болсон гэж бодож байна. Өнөөдрийн эдийн засгийн төлөв байдалд тааруулсан шийдвэр. Хэрвээ эдийн засаг улам хүндрээд, санхүүгийн нөхцөл байдал муудвал Монголбанкны энэ шийдвэр хэр удаан үргэлжлэх вэ, үүнээсээ буцах уу гэдэг асуудал яригдах учраас үүнд маш болгоомжтой хандаж байгаа. Бодлогын хүүг 6 хувьд хүргэсэн нь бидний хувьд байж болох хамгийн доод түвшин гэж ойлгож болно. Учир нь төгрөгийн өгөөжийг зах зээлийн хүү л тодорхойлж байдаг. Тэгэхээр төгрөгийн өгөөжийг багасгах тусам ялангуяа Монгол шиг хөрөнгийн бирж хөгжөөгүй, багахан хэмжээний хуримтлал бий болгож байгаа хувьд сонголтгүй зах зээлийн орчин байна. Нэгэнт сонголтгүй байгаа энэ үед төгрөгийн өгөөжийг бууруулбал, хөрөнгө гадагшлах муу үр нөлөө үзүүлэх магадлалтай. Тийм учраас бодлогын хүүг 6 хувьд хүргэсэн нь Монголбанкны хувьд үзүүлж болох хамгийн боломжит бага түвшинд хүргэсэн.

Ирэх онд эдийн засгийн төлөв байдал ямар байх вэ. Энэ оны хувьд Монголбанк эдийн засгийн өсөлтийг -2.6 хувь гэж төсөөлж байсан. Төсөөллөө шинэчилсэн үү?

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ГАЗАР (МБГ)-ЫН ЗАХИРАЛ Б.БАЯРДАВАА:

2020 оны эдийн засгийн өсөлтийг есдүгээр сард болсон Мөнгөний бодлогын хорооны хурлаар -2.6 хувь гэж тооцсон байсан. Үүнд авсан хамгийн гол таамаглал нөхцөл нь дотоод эдийн засагт цар тахал тархахгүй гэсэн нөхцөлд тулгуурласан. Үүнд үндэслээд, 2021 гуравдугаар улирлын эдийн засгийн өсөлт +1 орчим хувьтай гарна. Дөрөвдүгээр улиралд 5 хувийн өсөлттэй гарна гэсэн төсөөлөлд үндэслэн, ирэх жилийн эдийн

засгийн өсөлтийг 8 орчим хувьтай гарна гэж тооцоолсон. Дотоодод цар тахал тархаж, хатуу хөл хорио, бүх нийтийн бэлэн байдал зарласан нь эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж байна. Энэ утгаараа эдийн засгийн өсөлтийн 2020 оны төсөөллийг хасах 2.6-аас хасах 5.4 хувь болгож буурууллаа. Ерөнхийд нь хэлбэл, Мөнгөний бодлогын хорооны мэдэгдэлд дурдсанчлан энэ тооцоо судалгаа өмнө нь хийгдэхдээ цар тахал дотоодод тархахгүй буюу тодорхой бус байдал гадаад талдаа байна гэж үзэж байсан. Харин одоо тодорхой бус байдал гадаад болон дотоодод бий болоод байна. Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг бууруулахад худалдаа болон үйлчилгээний салбар голлон нөлөөллөө. Мөн уул уурхайн салбар харьцангуй сэргэлттэй байгаа ч бодит гүйцэтгэл хүлээлтээс доогуур байгаа нь эдийн засгийн өсөлтийн төсөөллийг бууруулахад хүргэж байна. Нөгөө талаас эдийн засгийн өсөлтийн шинэчилсэн төсөөлөлд үндэслэн инфляцын хүлээлтийг тооцоход өмнөх төсөөллөөс нэлээд буурч, 1-2 пунктээр бага байх урьдчилсан тооцоо байна.

Хувийн хэвшлийг мөнгөний бодлогоор хэрхэн дэмжих вэ, өр зээлээ төлж, ажилчдынхаа цалинг тавьж чадахгүйд хүрлээ гэсэн асуудлыг аж ахуйн нэгжүүд ихээр тавьж байна.

(МБГ)-ЫН ЗАХИРАЛ Б.БАЯРДАВАА:

Эдийн засагт үүсээд байгаа энэхүү нөхцөл байдал нь хэд хэдэн үр дагавартай байна. Нэгдүгээрт дотоод үйл ажиллагааны идэвхжил сулрах нөлөөтэй. Хоёрдугаарт, дотоод үйл ажиллагаа хумигдаж, бизнес, өрхийн орлого саарснаар банкны салбарт эрсдэл хуримтлагдаж, тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл бий. Энэ байдалд үндэслээд Монголбанкны зүгээс эдийн засагт болон банкуудад нийлүүлэх санхүүжилтийн цонхуудад өөрчлөлт оруулах, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зуучлалыг хэвийн хэмжээнд нь хадгалах, эдийн засагт нийлүүлэх санхүүжилтийг тодорхой түвшинд нь хадгалах зорилготой өөрчлөлт хийж байна. Энэ хүрээнд харьцангуй урт хугацаатай дахин санхүүжилтийн хэрэгслийг өмнөх репо санхүүжилтийн хэрэгсэлд суурилан нэвтрүүлж байна. Энэхүү дэмжлэг нь санхүүжилтийн нөхцөлийг бууруулах, зээлийн нийлүүлэлтийн өртгийг бууруулах зэрэг нөлөөтэй. Түүнчлэн үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор өрх, аж ахуйн нэгжүүд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын

142 ГАРУЙ МЯНГАН ЗЭЭЛДЭГЧИЙН 4.3 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА

Ковид-19 цар тахлаас үүдэн эдийн засагт хүндрэл үүсч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсч, зээлийн эрсдэлийн зардал нэмэгдэх, иргэд, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дарамт бий болох бодит эрсдэл үүссэн. Иймд эдгээр эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанкнаас баталж, банкуудад мөрдүүлдэг "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам", "Өр, орлогын харьцааг тооцох аргачлал", "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-д тус тус холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, зээлийн хугацаа болон бүтцэд өөрчлөлт оруулах, хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэв. Тус зохицуулалтын арга хэмжээний хүрээнд банкуудаас системийн хэмжээнд 2020 оны 12 дугаар сарын 18-ны байдлаар давхардсан тоогоор 142 гаруй мянган зээлдэгчийн 4.3 их наяд төгрөгийн зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, банкууд нийт 127 гаруй мянган зээлдэгчийн 1.6 их наяд төгрөгийн хэрэглээний зээл болон 2.7 их наяд төгрөгийн 15 гаруйн мянган бизнесийн зээл (үүнд: аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон зээл орно)-ийн бүтцэд өөрчлөлт оруулж, төлбөрийн нөхцөл, хуваарьт өөрчлөлт оруулж, хөнгөлөлт үзүүлсэн байна.

АРВАНХОЁРДУГААР САРЫН БАЙДЛААР ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРТ 390 ГАРУЙ ИРГЭН ХАМРАГДАЖ, 44 МЯНГА ГАРУЙ ЗЭЭЛИЙН ТӨЛӨЛТИЙГ ХОЙШЛУУЛЖЭЭ

Монголбанк болон банкны эх үүсвэрээр 2020 оны 10 дугаар сард нийт 926 зээлдэгч 65.7 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 6 хувийн хүүтэйгээр авч, ипотекийн зээлийн хөтөлбөрт хамрагдаад байна. Энэ оны 11, 12 дугаар сард Монголбанкнаас 60 тэрбум, банкуудын өөрийн эх үүсвэрээр 40 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөсөн бөгөөд зээл олголт үргэлжилж байна.

Корона вирусний дотоодод тархсан халдварын улмаас бүх нийтийн бэлэн байдал тогтоосон нь банкуудын салбар, нэгж болон бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үйл ажиллагааны хязгаарлалтаас болж, шинээр зээл олгох үйл явц удаашралтай байна. Банкуудаас ирүүлсэн мэдээллээр 2020 оны 11 дүгээр сараас 12 дугаар сарын 18-ний өдрийн хооронд нийт 24.7 тэрбум төгрөгийн зээлийг 394 өрхөд олгожээ.

Банкууд орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг цахим хэлбэрээр авч эхэлсэн өдрөөс хойш 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн байдлаар нийт 47,621 хүсэлтийг хүлээн авч, 44,443 хүсэлтийг буюу 93 орчим хувийг нь шийдвэрлэж эргэн төлөлтийг хойшлуулжээ. Үүний зээлийн үлдэгдэл нь 2.4 их наяд орчим төгрөг буюу нийт ипотекийн зээлийн багцын үлдэгдлийн 66 орчим хувийг эзэлж байна.

АСУУЛТ, ХАРИУЛТ

хүндрэлд орж байна гэж хэлж болно. Энэ хүндрэлийг зөөлрүүлэх арга хэмжээг төв банкнаас авч хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд банкны системээс гарсан зээлүүдэд хугацааг нь хойшлуулах арга хэмжээ авч байгаа нь аж ахуйн нэгж, өрхийн санхүүгийн дарамтыг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байгаа.

Мөнгөний бодлогын хүүг бууруулснаар 2007 оноос хойш хамгийн бага түвшинд хүрлээ. Энэ нөлөө хэзээ гарах вэ, авч байгаа арга хэмжээнүүд байгаа онож байна уу? Ялангуяа макро зохистой бодлогын шийдвэрүүдийн талаар?

МБГ-ЫН ЗАХИРАЛ Б.БАЯРДАВАА:

2007 онд Монголбанк анх бодлогын хүүг нэвтрүүлсэн. Ингэхдээ 6.4 хувиар нэвтрүүлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд энэ түвшнээс бууж байгаагүй. Харин одоо 6 хувийн түвшинд хүрч, буурлаа. Ингэж бууруулж байгаагийн нэг үндэслэл нь төв банкны тооцоо, судалгаанд үндэслээд харахад эдийн засгийн тогтвортой байдлыг сэргээх, дунд хугацаанд инфляцын зорилтыг алдагдуулахгүй байх боломжтой гэж үзсэнээр энэ жилийн хувьд нийтдээ 5 нэгж хувиар бодлогын хүүг бууруулсан. Макро зохистой бодлого мөнгөний бодлогын шийдвэрийн хүрээнд санхүүгийн нөхцөлийг зөөлрүүлэх арга хэмжээнд түлхэц болж өгч байгаа. Үүнд хэд хэдэн арга хэмжээг дурдаж болно. Долларжилтыг бууруулахтай холбоотой арга хэмжээ өмнө нь авагдсан. Үүнийг дагаад өнөөдрийн шийдвэрээр банкны заавал байлгах нөөцийг 2.5 нэгж хувиар бууруулснаар 400 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэрийг чөлөөлж өгч байна. Энэ нь эх үүсвэр чөлөөлөхөөс гадна банкны хөрвөх чадвар өндөртэй активын өгөөжийг дэмжсэн арга хэмжээ болж байгаа учраас банкны зүгээс зээлдэгч нартайгаа харьцахдаа санхүүгийн уян хатан нөхцөлийг бий болгох, гэрээгээ шинэчлэх боломжийг нэмэгдүүлж байгаа. Нөгөө талаас зээлийн төлбөрүүдийг хойшлуулж байгаа нь бизнес болон иргэдийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварт учирч байгаа хүндрэлийг хойшлуулж, зөөллөж өгч байгаа учраас мөнгөний бодлогын шийдвэрийг дэмжиж өгч байгаа юм.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ


2020 оны 11 дүгээр сар

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)




Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)




- Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс **13.6** хувиар өсч **23.3** их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн **8.4** нэгж хувийг төгрөгийн хадгаламж, **7.3** нэгж хувийг гадаад валютын хадгаламж, **-1.7** нэгж хувийг гадаад валютын харилцах, **-0.9** нэгж хувийг төгрөгийн харилцах, тус тус бүрдүүлж байна.
- M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн **19.1** их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн **4.2** их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 2.2. Зээлийн чанарын үзүүлэлт



- Нийт зээл **16.8** их наяд төгрөг (төгрөгийн зээл **15.3** их наяд, гадаад валютын зээл **1.5** их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **1.3%-**иар
- Хэвийн зээл өмнөх сараас **1.3%-**иар
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **3.8%-**иар буурч,
- Чанаргүй зээл өмнөх сараас **0.4%-**иар өссөн байна.

2. Зээл /үргэлжлэл/

Зураг 2.5. Хугацаа хэтэрсэн зээл (олгосон салбараар)



- Нийт хугацаа хэтэрсэн зээлийн **81.4%-**ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.


Зураг 2.6. Чанаргүй зээл (олгосон салбараар)



- Нийт чанаргүй зээлийн **74.3%-**ийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.


3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл



- Тайлант сард банкууд **581** эзэлдэгчид **41.4** тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос **70.7** хувь нь хөтөлбөрийн, **29.3** хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.


Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү




- Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс **2.9** нэгж хувиар, өмнөх сараас **1.6** нэгж хувиар тус тус буурч **8.6** хувьд хүрсэн байна.

4. Хүү

Зураг 4.1. Шинээр татсан хадгаламжийн хүү




Зураг 4.2. Шинээр олгосон зээлийн хүү



- 2020 оны 11 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) **10.2** хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ **2.7** хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс **0.8** нэгж хувиар буурчээ.
- Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ **15.8** хувь, гадаад валютын зээлийн ЖДХ **9.9** хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс **1.2** нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна

*Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2020 оны эхний 11 сар /урьдчилсан/



МОНГОЛБАНК 2020 ОНД 23.6 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанкны 2020 оны эцсийн байдлаар худалдан авсан үнэт металлын хэмжээ оны нийт дүнгээр 23.6 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.3 тонноор нэмэгдэж, гадаад валютын нөөцийг 900 орчим сая ам.доллараар өсгөлөө. Энэ нь түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд сүүлийн 5 жилд худалдан авсан үнэт металл 100 тн-д хүрч, гадаад валютын улсын нөөцийг 3,7 тэрбум ам.доллараар нэмэгдүүлсэн юм.

Ийнхүү үнэт металлын худалдан авалт амжилттай өсөхөд Дэлхийн

зах зээл дээр алтны үнэ оны эхнээс 21 хувиар өссөн, томоохон алтны үндсэн орд ашиглалтад орж олборлолтын хэмжээ нэмэгдсэн, хууль бусаар алт хилээр нэвтрүүлэх нь буурсан зэрэг хүчин зүйлс нөлөөлөв. Түүнчлэн Монголбанкнаас Алт-2 хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор алт олборлогч аж ахуй нэгжүүдэд алтаар эргэн төлөх нөхцөлтэй урьдчилгаа төлбөрийн болон урт хугацаат санхүүжилтын үр алтны салбарын экспортын хэмжээ 2020 оны 11 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 5 дахин өсч 1,7 тэрбум ам.долларт

хүрснээр Монгол Улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдал бага байхад томоохон хувь нэмэр оруулав. Мөн өнгөрсөн жилүүдэд Дархан-Уул, Баянхонгор аймагт үнэт металл худалдан авдаг болж, үнэт металлын арилжаа эрхлэгч иргэдэд тусгай зөвшөөрөл олгох, үнэт металлын сорьцын шинжилгээний үр дүн болон төлбөр төлөх зэрэг үйлчилгээнүүдийг цахимжуулсан гэх мэт үр дүнд Монголбанкинд худалдах үнэт металлын хэмжээ ийнхүү өслөө.



БАНКУУДАД 2020 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД 230 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН РЕПО АРИЛЖААГААР САНХҮҮЖИЛТ ОЛГОВ

Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжинтэй ярилцлаа.



Монголбанкнаас уул уурхайн бус экспорт болон ЖДҮ-ийн салбарыг дэмжих репо санхүүжилтийг нэвтрүүлж, 2020 оны 4 дүгээр улиралд 230 тэрбум төгрөгийг олгохоор болсон. Энэ санхүүжилт банкуудад бүрэн олгогдсон уу, хэчнээн аж ахуйн нэгж репо санхүүжилтэд хамрагдсан бэ?

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны хурлаар уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжих зорилгоор Монголбанкнаас урт хугацаатай санхүүжилт банкуудад олгохоор болсон. Энэхүү шийдвэрийн дагуу Монголбанкнаас 2020 оны 4 дүгээр улиралд банкуудад репо арилжаагаар нийт 230 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Энэхүү санхүүжилтийн хэмжээг Мөнгөний бодлогын хорооноос улирал бүр тогтоож байх бөгөөд 2021 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөгийн репо арилжаа хийхээр шийдвэрлэсэн байгаа. Бидний тооцоолсноор 230 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 750 гаруй жижиг, дунд үйлдвэр

эрхлэгчид авах боломжтой гэсэн тооцоо бий. Бид санхүүжилтийг аль болох хүртээмтэй байлгах зорилгоор зээлийн хэмжээн дээр хязгаар тогтоосон. Тэгэхээр ЖДҮ эрхлэгчид 300 сая төгрөг хүртэлх, уул уурхайн бус экспортын салбарын аж ахуйн нэгжүүдийн хувьд 1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг харилцагч банкнаасаа 2 жилийн хугацаатай, 10.5 хувийн хүүтэйгээр авах боломжтой. Банкууд 2021 оны 1 дүгээр сарын 15-ны дотор Монголбанкнаас авсан санхүүжилтээ бүрэн ашиглаж дуусгах үүрэгтэй байгаа.

Сүүлд Мөнгөний бодлогын хороо хуралдахад 2021 оны эхний улиралд 250 тэрбум төгрөгийн репо санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. Банкууд энэ санхүүжилтийг хэзээ авах вэ, түүнчлэн репо санхүүжилтийн эрэлт хэр их байна вэ?

Мөнгөний бодлогын хорооноос эдийн засгийн нөхцөл байдал, иргэд аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийн нөхцөлийг харгалзан үзсэнээр улирал бүр санхүүжилтийн хэмжээг тогтооно.

Монголбанкны дотоод тооцооллоор жилдээ 1 их наяд орчим төгрөгийн санхүүжилтийг олгоод явах боломж бий. Бид эхний зээлүүдийг үнэт цаасжуулсны дараа уг үнэт цаасаар дахин репо арилжаа хийхээр төлөвлөж байна. Иймд дараагийн санхүүжилт 2-3 дугаар сард хийгдэх болов уу.

Ипотекийн зээлийг хойшлуулах талаар шийдвэр гаргасан. Өнөөдрийн байдлаар хэчнээн иргэн зээлийн төлөлтөө хойшлуулаад байна вэ?

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу УИХ-ын 32 дугаар тогтоол гарснаар ипотекийн зээлийн эргэн төлөлтийг 6 хүртэлх сараар хойшлуулахаар болсон. Түүнчлэн ипотекийн зээлийн хугацаа хойшлуулаагүй зээлдэгчдэд 2 нэгж хувийн хүүгийн хөнгөлөлтийг 3 сарын хугацаанд олгохоор тус тус шийдвэрлэсний дагуу 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг

иргэдээс харилцагч банкууд авч, шийдвэрлэж ажилласан. Үр дүнд нь 2 их наяд гаруй төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 38,152 зээлдэгчийн хүсэлтийг шийдвэрлэж зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан нь ипотекийн зээлийн багцын 59 хувийг эзэлж байна.

Харин өнгөрсөн оны 11 дүгээр сард уг шийдвэрийн хэрэгжих хугацааг сунгасан. Энэ дагуу иргэд ипотекийн зээл төлөлтийг 2021 оны 7 дугаар сар хүртэл хойшлуулах боломжтой бөгөөд банкууд иргэдийн хүсэлтийг 1 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл цахим хэлбэрээр авч байна. 2021 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн байдлаар нийт 51,996 хүсэлт гаргаснаас 51,259 хүсэлтийг буюу 99 орчим хувийг бүрэн шийдвэрлэж, эргэн төлөлтийг хойшлуулсан байна. Энэхүү эргэн төлөлт хойшлуулсан зээлийн үлдэгдэл нь 2.7 их наяд орчим төгрөг буюу нийт ипотекийн зээлийн багцын үлдэгдлийн 75 орчим хувийг эзэлж байна.

Энэ оны хувьд төгрөгийн ханшид хэр дарамт ирэх төлөвтэй байна вэ, тооцоо судалгааг хийж байгаа юу?





Цар тахалтай холбоотойгоор эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж байгаа ч Монголбанкны тооцоо, судалгаагаар ханш тогтвортой байх төлөвтэй байна. 2020 онд төгрөг ам.долларын эсрэг 4.2 хувиар суларсны ихэнх нь 2020 оны 1 дүгээр улиралд бий болсон. Тодруулбал, нэгдүгээр улиралд нүүрсний экспорт саатаж, эдийн засагт нэлээд хүндрэл гарч байх үед төгрөг сулрах хандлага бий болсон. Хоёрдугаар улирлаас нүүрсний экспорт сэргэснээр эдийн засаг

тогтворжсон. Энэ утгаараа гадаад худалдааны тэнцэл 11 дүгээр сарын байдлаар 2 тэрбум ам.долларын ашигтай гарч, төлбөрийн тэнцлийн алдагдал ч багагүй хэмжээгээр буурсан. Тийм учраас 2020 оны хоёрдугаар хагасаас хойш ханш нэлээд тогтвортой байна. Монголбанкнаас арилжааны банкуудад нийлүүлдэг валютын хэмжээ 2020 оны есдүгээр сараас хойш эрчимтэй буурч байгаа. Өнгөрсөн оны эхэнд Монголбанк нэг удаагийн дуудлага худалдаагаар дунджаар 50 сая ам.долларын худалдан авах саналыг банкуудаас авдаг байсан бол сүүлийн үед энэ

хэмжээ эрчимтэй буурч, 10 гаруй сая ам.долларын санал л банкуудаас ирж байна. Монголбанкнаас энэ хандлага цаашид үргэлжилнэ гэсэн хүлээлттэй байгаа. Мөн 2020 оны эцэст Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 23.2 тоннд хүрч, гадаад валютын албан нөөц 4.5 тэрбум ам.доллар буюу мөн л түүхэн дээд хэмжээнд хүрлээ. 2021 оны хувьд төлбөрийн тэнцэл 521 сая ам.долларын ашигтай гарна гэсэн хүлээлттэй байгаа. Тэгэхээр энэ бүх макро эдийн засгийн үзүүлэлтүүд ханшийн дарамт бага байна гэдгийг илтгэж байгаа юм.



ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 31/ХИ ӨДРИЙН БАЙДЛААР)



КОВИД-19 БА ЗЭЭЛИЙН ТАСАЛДАЛ

Зохиогч: Кармен Рэихарт, Дэлхийн банкны дэд Ерөнхийлөгч,
Ерөнхий эдийн засагч
2020.12.02

Ковид-19-ийн хямрал нь санхүүгийн асуудлаас шалтгаалаагүй боловч хүссэн хүсээгүй дэлхий улс орнуудад санхүүгийн хямралыг үүсгээд байна. 2020 он тэр чигтээ цар тахлын тархалт, үйлдвэрлэлийн бууралт, ядуурал болон ажилгүйдлийн өсөлт гэх мэдээллүүд дунд өнгөрлөө. Эдгээр сэтгэл түгшээсэн чиг хандлагын цаана санхүүгийн тэнцлийн хямрал улс орнуудад нүүрлэж байна. Энэхүү хямрал нь улс орнуудын байршил, эдийн засгийн чадавхи зэргээс үл хамааран цар тахлын улмаас санхүүгийн хямралд өртөх эрсдэлтэй байгаа нь үнэн. Санхүүгийн байгууллагуудад ч чанаргүй зээл өссөөр байгаа бөгөөд цаашид энэ байдал үргэлжилсээр байх болов уу.

Түүхээс харвал, банк санхүүгийн хямрал нь ихэвчлэн урт хугацаанд үргэлжилсэн эдийн засгийн өрнөлийн дараа тохиосон байдаг. Энэхүү өрнөл нь ихэвчлэн зээлийн огцом өсөлт болон санхүүгийн хөшүүрэг (өр зээл)-ийг хэт их ашигласны үр дүнд үүсдэг. “Энэ удаагийнх өөр” байх болно гэсэн уриан дор Библид бичигдсэн “өнтэй долоон жил”-тэй адил хөрөнгийн үнийн хөөсрөлтийг бий болгох (энэ нь үл хөдлөх хөрөнгө, түүхий эд, хувьцаа эсвэл бонд ч байж болно) нь түгээмэл. Харин эдийн засгийн тэлэлт удаашраад эхлэхэд хямрал бий болж “өнтэй” цагт олгосон зээлийн чанар гэнэт муудаж эхэлдэг. Тайлан тэнцлийн асуудлууд нь заримдаа итгэлцлийг үгүй хийж банк, санхүүгийн байгууллагын хямралыг бүрэн утгаар нь паник болгож гүнзгийрүүлдэг. Хямралын дараа иргэд, ААН-үүдийн зээлийн хэмжээ буурахын зэрэгцээ банкууд ч зээлийн

нөхцөлөө чангаруулах нь түгээмэл. Гэхдээ хэрэв банкууд муу зээлүүдийг төлөгдөнө хэмээн үзэж дахин санхүүжилт хийн, өмнөх зээлийг төлүүлсээр байвал 1990-ээд оны эхэн үеийн Японы хямрал, 2007-2009 оны Европын хямралын үе шиг зээлийн тасалдал илүү удаан хугацаанд, ноцтой өрнөж Библи дэх “ган гачгийн долоон” жилээс ч урт хугацаанд үргэлжилж магадгүй юм.

Гэвч энэ удаад үнэхээр ялгаатай байна. 2021 онд үүсч болзошгүй байгаа зээлийн тасалдал бол олон орнуудын түүхэн өсөлт-уналтын шалтгаанаас тэс өөр байна. Энэ удаагийн зээлийн тасалдал эдийн засгийн огцом тэлэлт эсвэл хөрөнгийн үнийн хөөсрөлтийн аль алианаас шалтгаалаагүй. Түүхээс харвал эдийн засгийн идэвхжил огцом унаж, санхүүгийн тэнцлийн хямрал нүүрлэх үед зээлийн тасалдал бий болдог. Харин энэ удаагийн хямрал нь өөрсдийгөө дампуурлаас сэргийлэх боломж багатай жижиг дунд үйлдвэр болон бага орлоготой айл өрхүүдэд илүүтэй нөлөөлж байна.

Цар тахлын өмнөх их хэмжээний хөшүүрэг (өр зээл) нь санхүүгийн салбар дахь санхүүгийн тэнцлийн асуудлыг улам хурцатгах болно. АНУ, Хятад зэрэг дэлхийн тэргүүлэх эдийн засаг бүхий улс орнуудын ААН-үүд их хэмжээний өртэй төдийгүй, эрсдэл өндөртэй зээл олгогчдод хамаарч байна. ОУВС-аас цар тахлын өмнө хөгжиж буй зах зээлүүд дэх корпорацууд хэт их хөшүүрэг ашиглаж, ам.доллараар илэрхийлэгдсэн их хэмжээний зээлтэй байна хэмээн анхааруулж байсан. КОВИД-19



Эх сурвалж: Дэлхийн банк албан ёсны блог <<https://blogs.worldbank.org/developmenttalk/coming-covid-19-credit-crunch?fbclid=IwAR3qfwOnl-kR1sreXbP0rnQAo4fW0LjrRy5aVpsJNP110FddikCwl3JsBOW>>

цар тахлын дэгдэлтээс хойш хагас жил өнгөрөхөд S&P агентлагаас Латин Америкийн компаниудын бараг 60 орчим хувийнх нь зээлжих зэрэглэлийг бууруулж, төлөвийг сөрөг болгожээ. Бусад улс орнууд дахь компаниудын 35-40 хувь нь ижил нөхцөл байдалтай байна. Дэлгүүрүүд, арилжааны үл хөдлөх хөрөнгүүдийн түрээсийн талбай эзгүйрч байгаа нь дэлхийн улс орнуудын бас нэг санаа зовоох асуудал боллоо.

Австрали, Канад болон бусад орнуудад иргэдийн өрийн түвшин дээд хэмжээндээ хүрсээр байна. Африкт, 2019 онд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 11% байсан бол Африк дахь бичил зээл олгогч институтууд орлого нь тогтворгүй, хөрөнгө багатай өрх гэрүүдэд хэт их зээл олгосны улмаас эргээд зээлийн багцад нь өндөр дарамт тулгарч эхэллээ. Энэтхэг улсын хувьд, цар тахалтай нүүр тулах үедээ чанаргүй зээл нь аль хэдийнээ 9 хувьд хүрчихээд байсан бөгөөд сүүлийн жилүүдэд шинээр олгох зээл нь зөвхөн төрийн банкуудынхаа тэнцлийг цэвэрлэхэд л чиглэж байгаа.

Цар тахал нүүрлэснээс хойш ажил, орлогогүй болсон айл өрхүүдийг дэмжих, хорио цээрийн улмаас үйл ажиллагаа нь зогссон бизнес эрхлэгчдэд хөрвөх чадварыг бий болгохын тулд дэлхийн улс орнуудын засгийн газраас олон төрлийн бодлогын арга хэмжээг авсаар байна. Зээл төлөлтийг хойшлуулах боломжийг өмнө нь олгогдсон зээлүүдэд нээж өгсөн. Мөн зээлийн эргэн төлөлтийн хугацааг уртасгах, хүүгийн түвшинг

бууруулах явдал түгээмэл арга хэмжээ болж байна. Эрүүл мэндийн хямрал төдийгүй айл өрх, ААН-ийн санхүүгийн энэхүү хүндрэл нь түр зуурынх гэж бид найдсаар байна. Гэвч, бүх нийтэд вакциныг түгээж цар тахлын хариу арга хэмжээг шуурхай авсан ч дэлхийн эдийн засаг болон санхүүгийн байгууллагуудын баланс, санхүүгийн нөхцөл байдалд аль хэдийнээ хохирол үүсээд байгаа нь илэрхий юм.

Онц байдлын энэ үед, сангийн болон мөнгөний уламжлалт бодлогоос илүү дээрх “уламжлалт бус” бодлогын арга хэмжээнүүд нь үр дүнгээ өгч байгаа болов уу. Гэвч 2021 он гэхэд зээл хойшлуулах бодлогын хугацаа дуусч, хямралд өртөөд буй тоо томшгүй олон айл өрх, ААН-үүд хөрвөх чадваргүй, цаашлаад төлбөрийн чадваргүй болсон нь илэрхий болох болно. Хямралын үед зээлийн тасалдал нь эдийн засгийн сэргэлтийг хазаарладаг байсан. Харин цар тахлын дараах нөхцөл байдлаас харахад энэ удаад өөр байна гэсэн таамаглал бага ч болов бий болж байна.

Эх сурвалж: Дэлхийн банк албан ёсны блог <<https://blogs.worldbank.org/developmenttalk/coming-covid-19-credit-crunch?fbclid=IwAR3qfwOnl-kR1sreXbP0rnQAo4fW0LjrRy5aVpsJNP110FddikCwl3JsBOW>>

“ХАРХОРУМ 800 ЖИЛ” ДУРСГАЛЫН ЗООС



Он: 2020

Металл: Мөнгөн зоос

Жин: 62.2

Диаметр: 50 мм

Үнэ: 600,000₮

Сорьц: 999

ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ

О.Цолмон¹, Э.Хосбаяр²

JEL ангилал:

Түлхүүр үг:

Ковид-19, цар тахлын эсрэг арга хэмжээ, PATRI-X

Хураангуй:

Ковид-19 цар тахлын эсрэг улс орнуудын хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг хэмжих, эрэмбэлэх зорилгоор БНУнгар улсын төв банкны Pandemic treatment index (PATRI-X)-ийг нийт 89 улсын хувьд тооцооноор Монгол Улс нийт 89 улсаас 45-д эрэмбэлэгдэж байгаа бөгөөд манай орон эрүүл мэндийн үзүүлэлтээр маш сайн үнэлгээтэй гарсан боловч эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтээр тааруу үнэлгээ авлаа. Мөн улс орнуудын үр дүнг газар зүйн байршлаар нь харвал, Азийн орнууд Ковид-19-ийн эсрэг сайн арга хэмжээ хэрэгжүүлж байгаа бол Америк тивийн орнуудын арга хэмжээ төдийлөн хангалтгүй байна. Түүнчлэн бид PATRI-X индексийн хамгийн гол хязгаарлалт болох тухайн орны макро эдийн засгийн онцлогийг харгалзан үзээгүй байдлыг засах зорилготойгоор шинэ индекс тооцсон юм. Шинэ тооцооллын үр дүнгээр ихэнх улс (89 улсаас 77 улс)-ын эрэмбэд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй бол 11 улсын эрэмбэ мэдэгдэхүйц (20-оос дээш байраар) өөрчлөгдлөө.

1. Танилцуулга

Улс орнуудын цар тахлын эсрэг авч буй арга хэмжээний үр нөлөөг хэмжих зорилгоор БНУнгар улсын төв банкнаас улс орнуудын цар тахлын эсрэг авч буй арга хэмжээний үр нөлөөг хэмжих зорилгоор хөгжүүлсэн аргачлал болох Pandemic treatment index (PATRI-X)-ийн үр дүнг Монголбанкнд 2020 оны 8 дугаар сард ирүүлсэн юм. Монголбанкны зүгээс Ковид-19 цар тахлын үед улс орнуудын хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг хэмжих, тэдгээрийг эрэмбэлэх нь ач холбогдолтой гэж үзсэн тул тус аргачлалыг ашиглан улсуудын цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй бодлогын үнэлгээг хийхийг зорилоо. Ингэхдээ зөвхөн Европын 27 улсын хувьд тооцсон байсныг өргөтгөн нийт 89 улсын хувьд тооцсон болно.

Зураг 1. Улс орнуудын цар тахалтай тэмцэж буй бодлогын арга хэмжээний үнэлгээ (PATRI-X)



Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Ковид-19 цар тахал нь улс орнуудад олон хүнд, цоо шинэ сорилтыг бий болгож байна. Нэг талаар маш хурдтай тархаж буй өвчнөөс хүн амын эрүүл мэнд, амь насыг хамгаалах, нөгөө талаар эдийн засгаа эрүүл байлгаж, тогтвортой түвшинг хангах шаардлага үүсэж байна. Мөн энэхүү цар тахал, түүний эдийн засгийн сөрөг нөлөө хэр удаан үргэлжлэх нь тодорхойгүй тул төсөв, санхүүгийн хувьд тогтвортой байх шаардлагатай. Иймд цар тахлын үеийн сайн бодлого нь: 1) эрүүл мэнд; 2) эдийн засаг; 3) төсөв, санхүүгийн оновчтой бодлогоор хэмжигдэнэ (Зураг 2).

¹ Монголбанкны Судалгаа, статистикийн газрын эдийн засагч.
Цахим хаяг: tsolmon.o@mongolbank.mn

² Монголбанкны Судалгаа, статистикийн газрын дадлагажигч ажилтан.
Цахим хаяг: khosbayar.e@mongolbank.mn

Зураг 2. Цар тахлын үед хэрэгжүүлэх сайн бодлого



Эх сурвалж: Flaticon.com

2. Аргачлал, тоон мэдээлэл

PATRI-X индекс тооцоход ашиглагдах үзүүлэлт, тэдгээрийг нормчлох арга, нэгдсэн PATRI-X индекс тооцох аргын талаар болон ашигласан тоон мэдээллийн эх сурвалж, тайлбарыг дор үзүүлээ.

А. Үзүүлэлтүүд: Цар тахлын эсрэг улс орнуудын хэрэгжүүлж буй арга хэмжээг дан ганц үзүүлэлтээр хэмжих боломжгүй. Учир нь зөвхөн эрүүл мэндэд чиглэсэн бодлогод хэт анхаарах нь эдийн засаг, санхүүгийн хувьд хямрах, эсрэгээр дан ганц эдийн засгаа дэмжсэн бодлого хэрэгжүүлвэл халдварт өвчин хяналтгүй тархах эрсдэлтэй билээ. Иймээс улс орнуудын цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөөг эрүүл мэнд, санхүү болон эдийн засгийн талаас хамруулан хэмжих нь зүйтэй юм. Энэхүү PATRI-X аргачлал нь ерөнхий гурван бүлэг (а/ эрүүл мэнд, б/ эдийн засаг болон в/ төсөв, санхүүгийн)-ийн нийт 8 үзүүлэлтэд суурилан цар тахлыг хэрхэн амжилттай даван туулж байгааг илэрхийлэх индексийг тооцдог ажээ (Зураг 3).

Тухайлбал, тухайн орны эрүүл мэндийн бодлогын чанарыг илэрхийлэх үзүүлэлт болох Ковид-19-ийн тохиолдол, Ковид-19-ийн нас баралт, Ковид-19 бүс нутгийн аюулгүй байдлын индекс¹, мөн тухайн орны бодит эдийн засгийг илэрхийлэх үзүүлэлт болох эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийн өөрчлөлт, ажилгүйдлийн түвшин болон төсөв, санхүүгийн байдлыг илэрхийлэх төсвийн тэнцэл, урсгал дансны тэнцэл гэсэн үзүүлэлтийг тус индексэд ашигладаг байна.

Зураг 3. PATRI-X-ийн үзүүлэлтүүд

PATRI-X PANDEMIC TREATMENT INDEX		
ЭРҮҮЛ МЭНД	ЭДИЙН ЗАСАГ	ТӨСӨВ, САНХҮҮ
1. 100,000 хүнд ногдох COVID-19 тохиолдол 2. 100,000 хүнд ногдох COVID-19 нас баралт 3. COVID-19 safety ranking	1. Бодит эдийн засгийн өсөлт 2. Ажил эрхлэлтийн өөрчлөлт 3. Ажилгүйдлийн түвшин	1. Төсвийн тэнцэл 2. Урсгал дансны тэнцэл

Эх сурвалж: MNB, БНУУ-ын төв банк

¹ Хавсралт 2-оос дэлгэрэнгүй харна уу.

Б. Үзүүлэлтийг нормчлох: Дээрх нэгдсэн индексийг тооцоход ашиглагдах үзүүлэлт нь өөр өөр хэмжигдэхүүнээр илэрхийлэгдэж байгаа тул бүх үзүүлэлтэд 0-100 хоорондох оноог оноож өгчээ. Тухайн үзүүлэлтээр хамгийн сайн оронд 100 оноо оноох бөгөөд үүнээс хэр хазайж байгаагаар бусад оронд оноог өгнө. Тухайлбал, хамгийн сайн онооноос 1 стандарт хазайлтын хэмжээгээр зөрвөл 25 оноог хасаж, 75 оноо өгөх ба 4-өөс илүү стандарт хазайлтаар зөрвөл "0" гэсэн оноо өгнө.

$$\text{MAX} \left(0; 100 - \left\{ \frac{([\text{хамгийн сайн оноо}] - [\text{тухайн улсын оноо}])}{[\text{стандарт алдаа}]} \right\} * [25] \right)$$

Жишээлбэл, Ковид-19 тохиолдлын хувьд хамгийн сайн буюу 100,000 хүнд 1.2 тохиолдол бүртгэгдсэн Вьетнам улсад 100 оноо өгнө. Нийт 90 улсын Ковид-19 тохиолдлын тооны стандарт алдаа нь 943 бөгөөд Монгол улсын хувьд 100,000 хүнд 10.3 тохиолдол бүртгэгдсэн тул $100 - \frac{10.3 - 1.2}{943} * 25 = 99.76$ өгнө.

Энэ дагуу 8 үзүүлэлт тус бүрээр улс орнуудад оноог өглөө.

В. Нэгдсэн индекс: Нэгдсэн индексийг 8 үзүүлэлтийн нормчилсон онооны арифметик дундаж байхаар тооцлоо.

$$\text{PATRI} - X = \text{Average}(X1, X2, X3, X4, X5, X6, X7, X8)$$

Г. Ашигласан тоон мэдээлэл: Тоон мэдээллийг сүүлийн үеийн, хүртээмжтэй, мөн найдвартай гэж үзсэн эх сурвалжаас цуглууллаа. Ковид-19-ийн тохиолдол, нас баралтын талаарх тоон мэдээллийг John Hopkins-ийн их сургуулийн мэдээллийн сан, Ковид-19 аюулгүй байдлын индексийг Deep Knowledge Group-ийн мэдээллийн сангаас тус тус авлаа. Харин эдийн засаг болон санхүүгийн үзүүлэлтийг ОУВС-аас гаргадаг World Economic Outlook-ийн тоон мэдээллийн сангаас ашигласан болно (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ашигласан тоон мэдээлэл


Үзүүлэлт	Эх сурвалж	Тайлбар
100,000 хүнд ногдох Ковид-19 тохиолдол	John Hopkins University	2020.10.25-ны байдлаар
100,000 хүнд ногдох Ковид-19 нас баралт	John Hopkins University	2020.10.25-ны байдлаар
Ковид-19 бүс нутгийн аюулгүй байдлын индекс	Deep knowledge group	2020.08.23-ны байдлаар
Бодит эдийн засгийн өсөлт	World economic outlook, IMF	2020 оны төсөөлөл, 2020.10.13
Ажил эрхлэлтийн өөрчлөлт	World bank	International Labour Organization, 2020.06
Ажилгүйдлийн түвшин	World economic outlook, IMF	2020 оны төсөөлөл, 2020.10.13
Төсвийн тэнцэл/ДНБ	World economic outlook, IMF	2020 оны төсөөлөл, 2020.10.13
Урсгал дансны тэнцэл/ДНБ	World economic outlook, IMF	2020 оны төсөөлөл, 2020.10.13

Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

3. Үр дүн

Тооцооллын үр дүнгээр, Монгол Улсын PATRI-X индексийн утга 50 оноо болж, нийт 89 улсаас 45-д эрэмбэлэгдлээ.² Харин БНСУ-ын хэрэгжүүлж буй бодлого нь хамгийн үр дүнтэй байгаа буюу PATRI-X индексээр хамгийн өндөр утга (74 оноо)-ыг авлаа. Норвеги, Вьетнам, Дани улс БНСУ-ын дараагаар эрэмбэлэгдсэн бол бодлогын нөлөө үр дүн муутай улс орнуудын тоонд Испани, Аргентин, Бразил, ӨАБНУ, АНУ зэрэг улс багтлаа (Зураг 4).

Зураг 4. PATRI-X оноо (улс орноор)



Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор


PATRI-X оноог газар зүйн байршил, орлогын ангиллаар нь харьцуулан харвал газар зүйн байршлын хувьд хамаарал ажиглагдсан боловч орлогын ангиллын хувьд ажиглагдсангүй болно.

Өөрөөр хэлбэл, өндөр хөгжилтэй улс орнуудын цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хөгжиж буй улсынхаас илүү үр дүнтэй гэсэн нотолгоо ажиглагдсангүй (өөрөөр хэлбэл, Ковид-19-ийн эсрэг хэрэгжүүлж буй бодлогын чанар нь тухайн улсын хөгжлөөс хамаарахгүй байна). Харин газар зүйн байршлаас хамаарч буй зүй тогтол ажиглагдлаа. Тухайлбал, Ази тивийн орнууд Ковид-19-ийн эсрэг сайн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа бол Америк

тивийн орнуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ нь бусад улс орнуудтай харьцуулахад хангалттай түвшинд биш байгаа нь үр дүнгээс харагдлаа (Зураг 1).

PATRI-X индексийг задалж харахад, Монгол Улс эрүүл мэндийн үзүүлэлтдээр хангалттай сайн үнэлгээ авсан боловч эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтээр тааруу үнэлгээ авсан нь манай орны хэрэгжүүлж буй арга хэмжээ нь дан ганц Ковид-19 цар тахлын эрүүл мэндийн хямралаас сайн хамгаалж байгаа боловч төсөв, санхүү болон эдийн засгийн хямралаас хамгаалахад чиглээгүй байгаа нь Ковид-19 тархалтаас сэргийлсэн хориг арга хэмжээг хэт их хэрэгжүүлснээс эдийн засгийн сөрөг нөлөөллийг нэмэгдүүлсэн байх талтай юм (Зураг 5).

Зураг 5. PATRI-X үзүүлэлтээр (Монгол, БНСУ, Испани)



Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Загварын хязгаарлалт (Limitation)

БНУУ-ын төв банкны PATRI-X аргачлал нь улс орнуудын цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөөг эрүүл мэнд, санхүү болон эдийн засгийн гэсэн бүлэг үзүүлэлтийг хамааруулан хэмжсэн онцлог, давуу талтай боловч загварт дараах хязгаарлалт байна.

- Тухайн орны онцлогыг харгалзан үзээгүй. Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, урсгал дансны

² Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу.

алдагдал, эдийн засгийн үзүүлэлт зэрэг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт нь Ковид-19 цар тахлаас илүүтэйгээр тухайн орны онцлогоос ихээхэн хамаардаг. Тухайлбал, манай орны хувьд урсгал дансны алдагдал өндөртэй орны тоонд багтдаг. Уг нөлөөг орхигдуулан үзүүлэлтийн абсолют дүнгээр улс орнуудуудыг эрэмбэлсэн нь загварын хязгаарлалт гэж үзэж байна.

- **Эдийн засгийн нөлөөнд голчлон анхаарсан.**

Уг аргачлалын дагуу 8 үзүүлэлт нь тэнцүү жинтэйгээр нэгдсэн индексэд нөлөөлдөг. Гэвч эдгээр 8 үзүүлэлтийн 3 нь тухайн орны эрүүл мэнд, 5 нь санхүү, эдийн засгийг илэрхийлэх үзүүлэлт байна. Иймд тус аргачлалаар эдийн засгийн нөлөөнд голчлон анхаарч, эрүүл мэндийн үзүүлэлтэд бага жин оноосон нь тооцооллыг хазайлттай гарахад нөлөөлөх талтай юм.

Шинэ PATRI-X индекс

Иймд бид PATRI-X индексийн хамгийн гол хязгаарлалт болох тухайн орны макро эдийн засгийн онцлогийг харгалзан үзээгүй байдлыг засах зорилготойгоор шинэ индексийг тооцлоо. Ингэхдээ санхүү, эдийн засгийн үзүүлэлт (*эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, ажилгүйдэл, төсвийн тэнцэл, урсгал дансны тэнцэл*)-ийн абсолют утгын оронд тухайн орны сүүлийн таван жилийн дундаж утгаас өөрчлөгдсөн хэмжээг ашиглалаа. Өөрөөр хэлбэл, тухайн үзүүлэлтийн Ковид-19-өөс шалтгаалсан өөрчлөлтийг тус орны онцлогоос салган авч үзэж байгаа юм.

Тооцооллын үр дүнгээр Египет улсын хэрэгжүүлж буй бодлого нь хамгийн үр дүнтэй байгаа буюу шинэ индексээр хамгийн өндөр (75 оноо) утгыг авлаа. Харин өмнөх тооцооллоор 1-д эрэмбэлэгдэж байсан БНСУ 5-д эрэмбэлэгдэв. Ерөнхий эрэмбээр нь үзвэл, ихэнх улс (89 улсаас 77 улс)-ын эрэмбэд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй буюу 20 байр дотор өөрчлөгдсөн бол 11 улсын эрэмбэ мэдэгдэхүйц (*20-оос дээш байраар*) өөрчлөгдлөө. Тухайлбал, Сингапур улс өмнөх PATRI-X индексээр 8-д эрэмбэлэгдэж байсан бол шинэ PATRI-X индексээр 31 байр ухарч 49-д эрэмбэлэгджээ. Үүнд Сингапур улс нь урсгал дансны өндөр ашигтай (*урсгал дансны ашиг сүүлийн 5 жилд дунджаар ДНБ-ий 17.3 хувь*), ажилгүйдлийн түвшин бага (*ажилгүйдэл сүүлийн 5 жилд дунджаар 2.1 хувь*) явж ирсэн бөгөөд 2020 он гарснаар ажилгүйдэл 3 хувь, урсгал дансны ашиг 15 хувь болж муудсан нь тус орны эрэмбийг бууруулахад нөлөөлсөн байна.

Монгол улсын хувьд өмнөх PATRI-X индексээр 45-д эрэмбэлэгдэж байсан бол шинэ PATRI-X индексээр 42-д эрэмбэлэгдэв. Ийнхүү байр урагшлахад урсгал дансны алдагдлын өөрчлөлт голлох нөлөөллийг үзүүллээ. Өөрөөр хэлбэл, манай орон урсгал дансны өндөр алдагдалтай (*урсгал дансны алдагдал сүүлийн 5 жилийн дунджаар -10.5 хувь*) байдаг тул өмнөх индексээр урсгал дансны үзүүлэлтээр хамгийн муу орны нэгд тооцогдож, нэгдсэн PATRI-X индексийн утга бага гарлаа.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН САНХҮҮГЭЭ ЗОХИЦУУЛАХАД ХЭ

Өнөөгийн нөхцөл байдал хэр удаан үргэлжлэх нь тодорхой бус байгаа тул өрх бүр одооноос эхэлж өөрийн санхүүгийн нөхцөл байдалдаа тааруулан хэмнэлт хийж зурших хэрэгтэй. Тиймээс дараах алхмууд таны зардлыг хасахад тус болох юм.




Сард хэрэглэж буй зардлаа тооцож гаргах

Та зардлаа танаж эхлэхийн тулд эхлээд та хэдий хэмжээний мөнгө сард зарцуулдаг гэдгээ мэдэх ёстой. Тийм учир дор хаяж нэг сарын турш худалдан авсан бүх зүйлээ үнийн дүнтэй нь тэмдэглэж явах хэрэгтэй.



Өрхийн төсөв зохиох

Сард үрж буй зардлаа мэдсэн бол түүн дээрээ хэрхэн хэмнэлт хийж болох тал дээр анализ хийх хэрэгтэй. Харин дараа нь ирэх сарынхаа өрхийн төсвийг зохиож хэдий хэмжээний хэмнэлт хийх гэж буй зорилгоо давхар тэмдэглэх хэрэгтэй.



Гэртээ хооллох

Гадуур хооллох болон хоол захиалах бус гэртээ хоол хийж идэх нь мөнгө хэмнэх хамгийн чухал аргуудын нэг юм. Хүмүүсийн гадуур хооллох эсвэл хоол захиалж идэх шалтгаан нь ажлаа тараад хоол хийхэд ядарсан эсвэл хэтэрхий оройтож хоолоо идэх шалтгаанууд байдаг. Тийм учир амралтын өдрүүдэд ирэх 5 хоногийн хоолны материалаа бэлдээд тавих хэрэгтэй.



Хуримтлуулах

Хэрэв танд хуримтлуулах боломж байвал бага ч гэлтгүй банканд хуримтлуулах хэрэгтэй. Учир нь энэхүү цар тахал хэдий хүртэл үргэлжлэх, хэр цар хүрээтэй байх нь тодорхой бус байгаа учир урт хугацаандаа санхүүгийн хямралд өртөхөөс сэргийлж буй арга юм.

ҮЕД ИРГЭДИЙН ӨРХИЙН РЭГЛЭЖ БҮЙ ТҮГЭЭМЭЛ АРГУУД

Хөрөнгө оруулах



Хэрэв та амжилттай зардлаа хасаж, хүсэл болон хэрэгцээгээ ялгаж худалдан авалт хийж байгаа бол та хэмнэсэн мөнгөнийхөө багахан хэсгийг хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглаж болох юм.

Гурилан бүтээгдэхүүнээ гэртээ хийж идэх



Зардлаа багасгах энгийн нэгэн арга бол гурилан бүтээгдэхүүнээ гэртээ хийх юм. Жишээ нь та дэлгүүрээс талх авч хэрэглэхийн оронд гэртээ өөрөө талхаа барьж идвэл багагүй хэмнэлт гарах юм.

Зээл авахаас аль болох татгалзах



Өнөөгийн цар тахалтай холбоотой эдийн засгийн тодорхой бус нөхцөл байдлын үеийг аль болох ирээдүйдээ хүндрэл учруулахгүйгээр даван туулахын тулд зээл хамаагүй авахаас татгалзах хэрэгтэй. Жишээ нь та зээлийн карттай бол тухайн дансаа түр зур хааж, зардалдаа хэмнэлт хийх хэрэгтэй. Энэ нь таныг дараа нь төлөх зээлийн өндөр хүүний төлбөрөөс хамгаалах юм.

Бүх өр төлбөр болон зээлийнхээ жагсаалтыг гаргах



Өрхийн төсөв зохиохоос гадна өр болон зээлийн эргэн төлөлтийн хугацаагаа бас давхар тооцох хэрэгтэй. Энэ нь таныг үнэн зөв төсөв зохиохоос гадна зээлээ цаг тухайд нь төлөх дадалд хэвшүүлж, зээлийн мэдээллийн сангийн муу ангилалд оруулахаас сэргийлэх юм.



Иргэдийн инфляцын хүлээлт

ТҮҮВЭР СУДАЛГААНД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА



Инфляцын талаарх
хүлээлтийг
тодорхойлоход оршино.



Та 5-10 минут л
зарцуулна.



Ковидын үеийн
хүндрэлийг
тодорхойлоход цэгцтэй
мэдээллийг өгнө.



Судалгаанд оролцогчдоос
180 хүнийг санамсаргүй
сонгон урамшуулна.



СУДАЛГААГ БӨГЛӨХ



Судалгаанд оролцсон Танд баярлалаа.

<https://www.mongolbank.mn/>

